MMINFO

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,142.935... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.05.16. Мягмар. №096 (4710) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

УЛС ТӨР

МАН-ЫН “60 ТЭРБУМ”-ЫН АСУУДЛААР МЭДЭЭЛЭЛ ӨГӨХИЙГ ДААЛГАЖЭЭ

II нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС

ЭРҮҮГИЙН ХУУЛЬ АЛДААТАЙ БОЛСОН, БОЛООГҮЙ

V нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР






Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

## Т.Бадрал: ТӨРИЙН ӨМНӨӨС ҮҮРЭГ ХҮЛЭЭДЭГ ХҮМҮҮСИЙН НИЙГМИЙН БАТАЛГАА ӨНДӨР БАЙХ ЁСТОЙ

Дэлгэрэнгүй ярилцлагыг VI нүүрнээс

ҮЗЭЛ БОДОЛ

## ОРХОН АЙМАГ ТЭРГҮҮЛЖ, ГОВЬ-АЛТАЙ СҮҮЛ МУШГИВ

Ч.ЧУЛУУН

Өрсөлдөх чадвар гэх ойлголт монголчуудын хувьд шинэ содон нэр томъёо биш. Энгийн иргэдийн хувьд БНМАУ зах зээлийн нийгэмд шилжсэн тэр он жилүүдэд л өрсөлдөх чадвар гээчтэй анх танилцаж байлаа. Эрээнээс оруулж ирсэн өмд гутал, элсэн чихэр, будаа гурил нь ” Дэнжийн мянга-“ын зах дээр элдэв явдал чирэгдэлгүйгээр маш хурдан зарагддаг байхын тулд сонголтоо зөв хийх явдал гэдгийг ойлгосон нь чухамдаа өрсөлдөх чадвар байсан бол эдүгээ үйлдвэрлэж байгаа бараа бүтээгдэхүүн нь чанартай, үнийн хувьд дэлхийн жишгээс үл ялиг хямд байх аваас дотоодын болон олон улсын зах зээлд өрсөлдөх чадвар нэмэгддэг гэдгийг хэдийнэ ойлгосон. Харин эдийн засгийн суурь онолд улс орны өрсөлдөх чадвар нь тухайн улс өөрийн нөөц баялагтаа тулгуурлан олон улсын зах зээлд үйлдвэрлэл үйлчилгээ үзүүлж, нэмүү ашиг олох чадварыг хэлнэ хэмээн тодорхойлсон байх юм. Мөн бүтээмж болон үр ашгийг өсгөж, инфляцийг хөөрөгдөлгүйгээр иргэдийнхээ орлогыг нэмэгдүүлэх суурь нь өрсөлдөх чадвар мөн хэмээж. Бас ажлын байр бий болгох, ядуурлыг бууруулах хүчин зүйл ч гэж ойлгож болохоор юм билээ. Дэлхийн улс орнуудыг хөгжил цэцэглэлтийг хэмжих хэмжүүр нь ч энэ аж. БНМАУ XX зуунд өрсөлдөх чадвараараа тэргүүлэгч улс орны тоонд зүй ёсоор багтаж байв. Тэр үед төрийн бодлого боловсрол, эрүүл мэндийн салбарын хөгжлийг эдийн засгаас илүүд үзэж байсан хэрэг. Бичиг үсэгт тайлагдахаас өгсүүлээд муу өвчинтэй 1960-аад оны дунд үе хүртэл тэмцэж байж арайхийн дарж авсан нь чухамхүү тухайн цаг үеийн хамгийн том ололт байлаа. Дэлхийн чиг хандлага нь өөрөө ийм байсан юм.

Үргэлжлэл нь III нүүрт

Дугаарын 60 мөр

## Хөхний сүү хуульчлахаас өөр хийх ажил алга уу

Б.ЭРХЭС

Өнгөрөгч долоо хоногийн УИХ-ын чуулганаар бас нэг “бантан” болсон хуулийн төслийг баталлаа. Хуулийн төслийн үзэл санаа нь нялх балчир үрсээ хамгаалах тухай гэнэ. Тэдний дархлааг дэмжиж, эхийн сүү хөхсөн хүүхэд эрүүл саруул өсч бойждог гэдгийг нийгэмд уриалах, сурталчлах зорилготой юм билээ. Цаашлаад, давжаа биетэй, өсөлтгүй болж байгаа балчир үрсийгээ төр хуулиар далайлган хамгаалж байгаа хэлбэр хэмээн хууль санаачлагчид тайлбарласан. Гэвч үндсэн зорилгоосоо тэс өөрийг хуулийг А.Цогцэцэг сайд батлуулж орхив. Ямар ч тооцоо судалгаагүй хууль гэдэг нь цахим ертөнцөд өрнөж буй шүүмжлэлээс илхэн харагдана. Тэр байтугай хүүхдийн эрхийг ноцтой зөрчсөн хэмээн хүний эрхийн хуульч, экс гишүүн Ц.Оюунгэрэл жиргэсэн байх юм. Өнгөрөгч оны арванхоёрдугаар сарын 27-нд салбарын сайд УИХ-ын даргад энэ хуулийг анх өргөн мэдүүлсэн байдаг. Нялх балчир хүүхдийн хоол, хүнсний бүтээгдэхүүний тухай хуулийн төслийг батлуулах шалтгаанаар тэрбээр “Сүүлийн жилүүдэд эхийн сүүг орлох бүтээгдэхүүний хэрэглээ өсч байгаа. Энэ хэрээр хүүхдийг эхийн сүүгээр хооллох нь багасч 60 хувь байсан үзүүлэлт 40 хувьд хүрч буураад байгаа” хэмээн тайлбарлажээ. Улмаар таван бүлэг, 20 зүйл, 56 заалт, 94 хэсэг бүхий нүсэр том хуулийн төслийг батлуулж чадлаа. Энэ хуулийн амин сүнс нь дээр хэлсэнчлэн нялх балчир үрсийнхээ хоол хүнсний асуудлыг анхаарах.

Үргэлжлэл нь III нүүрт

ДЭЛХИЙ

## Өмнөд Солонгосын шинэ Ерөнхийлөгч “ТҮРГЭН АВАВ”

Б.ДАВААХҮҮ

БНСУ-ын шинэ Ерөнхийлөгч Мүн Жэ Ин Япон руу тусгай элч төлөөлөгчөө илгээжээ. Өнгөрөгч ням гарагийн өглөө Пхеньян шинэ төрлийн баллистик пуужинг Япон тэнгисийн зүгт хөөргөн туршсан. БНСУ-ын ээлжит бус Ерөнхийлөгчийн сонгууль болж, хоёр Солонгосын харилцаанд эргэлт гаргахаа амласан Ардчилсан намын Мүн Жэ Ин үнэмлэхүй ялалт байгуулснаас хойш анх удаагаа пуужин туршсан нь энэ байлаа.

НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс тус улсыг цөмийн зэвсэг, пуужингийн хөгжүүлэлтээ нэн даруй зогсоохыг шаардан хориг арга хэмжээ авсаар байгаа ч, Хойд Солонгос тэдний шаардлагыг үл хайхран удаа дараа пуужин туршсаар байгаа юм.

Үргэлжлэл нь IV нүүрт

ОНЦЛОХ УЛС ТӨР

## Үндсэн хуулийг өөрчлөх нь тодорхой болов

Б.ЭРХЭС

УИХ-ын дарга М.Энхболдод өчигдөр УИХ-ын гишүүн, БОАЖ-ийн сайд Д.Оюунхорол “Ард нийтийн санал асуулгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”-ийг өргөн мэдүүллээ. 2016 онд Засгийн газраас Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэхийг судлах, санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Үндсэн хуулийн асуудлаар мэргэшсэн эрдэмтэн, судлаачдаас бүрдсэн Ажлын хэсгийг байгуулан, 21 аймаг, нийслэлд судалгаа явуулж, хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд Ажлын хэсэг Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаархи санал дүгнэлтээ гаргасан байдаг. Улмаар УИХ-аас гаргасан тогтоолын дагуу Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар зөвлөлдөх санал асуулгыг өнгөрөгч сарын 29, 30-ны өдрүүдэд зохион байгуулж зөвлөмж гаргаснаа УИХ-д хүргүүлсэн. Тэгвэл энэхүү зөвлөмжид үндэслэн Ард нийтийн санал асуулга явуулахаар хуулийн төсөлд өөрчлөлт оруулахаар болжээ. Улмаар ард нийтийн санал асуулгыг сонгууль болохоос 65 хоногийн өмнө зарлана хэмээн хуульд заасан ч Ерөнхийлөгчийн сонгууль болоход 45 хоног үлдээд байгаа учраас хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулж, хоногийг багасгахаар болсон аж.




| | ХААН банк Авах | Зарах | | Авах | Зарах | Худалдаа хөгжлийн банк Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2416.00 | 2430.00 | ФУНТ | 3084.00 | 3178.00 | 2418.00 | 2430.00 | ФУНТ | 3086.00 | 3160.00 |
| ЕВРО | 2613.00 | 2681.00 | РУБЛЬ | 41.80 | 43.90 | 2613.00 | 2679.00 | РУБЛЬ | 41.44 | 44.53 |
| ИЕН | 21.19 | 21.49 | ЮАНЬ | 349.30 | 352.50 | 21.06 | 21.61 | ЮАНЬ | 349.00 | 352.50 |

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

# УЛС ТӨР

ХААЛТТАЙ ХУРАЛДААН



## МАН-ын "60 тэрбум"-ын асуудлаар мэдээлэл өгөхийг даалгажээ

Б.ТОГТОХ

УИХ дахь Ардчилсан намын бүлэг өчигдөр ээлжит хурлаа хийж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Төрийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон УИХ-ын гишүүн Д.Тогтохсүрэн нарын гишүүдээс санаачилсан Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг тус тус хэлэлцжээ. Хуулийн төслийн хэлэлцүүлэгтэй холбоотой бүлгийн гишүүдэд УИХ дахь Ардчилсан намын бүлгээс байгуулсан ажлын хэсгийн ахлагч УИХ-ын дэд дарга Я.Санжмятав, Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Цогоо болон ажлын хэсгийн гишүүд мэдээлэл хийж санал бодлоо солилцсон байна. Д.Тогтохсүрэн нарын гишүүдээс санаачилсан Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгад Монгол Улсын Үндсэн Хууль болон бусад хуультай зөрчилдөж буй заалтууд нэлээд байгаа төдийгүй Төрийн албаны зөвлөлийн хараат бус байдалд нөлөөлөх Засгийн газраас төрийн албаны томилгоо, сонгон шалгаруулалтад дам болон шууд нөлөөлөх нөхцөл байдлыг үүсгэхээр зүйл заалтууд олон байгааг эргэж харж, Мэргэжлийн байгууллага хүмүүсийн саналыг тусган өөрчлөн найруулах, Олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэг хийх шаардлагатай гэж АН-ын бүлгийн гишүүд үзсэн байна. Мөн хуулийн төсөлд Үндсэн хуулийн 46.2 дахь хэсэгт заасан Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч гэсэн агуулга томъёоллыг орхигдуулсан, журам дүрмээр зохицуулах боломжтой олон зүйлийг хэт хавтгайруулан тусгасан, Төрийн албаны зөвлөлийн чиг үүргийг Засгийн газрын мэдэлд /ЗГХЭГ/ шилжүүлэн төвлөрүүлэхээр заасан байгаа нь Төрийн албаны зөвлөл, төрийн алба хаагчийн хараат бус тогтвортой ажиллах нөхцөлд сөргөөр нөлөөлөхөөр байна гэж дүгнэжээ. Тиймээс УИХ дахь Ардчилсан намын бүлэг маргааш Төрийн албаны зөвлөл болон бусад мэргэжлийн байгууллага, холбоодын оролцоотойгоор тус хуулийн төслийн нээлттэй хэлэлцүүлгийг Төрийн ордонд зохион байгуулахаар болсон аж. Мөн бүлгийн хурлын үеэр Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Цогоогоос бүлгийн гишүүд одоо мөрдөгдөж байгаа Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт, Сүхбаатар аймагт үүсээд байгаа улс төрийн нөхцөл байдлын талаар авч буй арга хэмжээний талаар мэдээлэл сонсчээ. Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Цогоогийн хэлж буйгаар "Сүхбаатар аймагт үнэхээр хууль зөрчсөн зүйл болсон. Төрийн албаны зөвлөлөөс байр суурьа албан тоотоор хатуу илэрхийлсэн байгаа. Өнөөдөр мөрдөж байгаа хуулиар ИТХ-ын гишүүн буюу улс төрийн албан тушаал хашч байгаа хүн төрийн Захиргааны алба давхар хаших хууль эрх зүйн ямар ч боломж байхгүй. Тиймээс Сүхбаатар аймагт хууль бусаар төрийн албанд ажиллаж байгаа гурван хүнийг ИТХ-даа, эсвэл төрийн захиргааны ажлыг нь хийлгэ" гэсэн шаардлага хүргүүлсэн. Харин аймгийн Засаг даргаас нь Төрийн албаны зөвлөлд хариу бичиг ирүүлсэн. Хариу бичигт "УИХ-ын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 12 гишүүний санаачилсан Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбоотойгоор тун удахгүй Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт орох гэж байна. Тиймээс тэр болтол энэ байдлаараа ажиллаж байх болно" гэсэн батлагдаагүй байгаа хуулийн төсөлтэй холбон, одоо мөрдөгдөж буй хуульд нийцээгүй албан тоот ирүүлсэн гэсэн хариулт өгчээ. Түүнчлэн сүүлийн үед төрийн албанаас 22365 хүн халагдсан. Үүнээс 3000 гаруй хүн тэтгэвэрт гарсан тухай Төрийн Албаны Зөвлөлийн дарга энэ үеэр мэдээлэл өгсөн аж. УИХ-аар хэлэлцэж буй Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр төрийн албаны тогтвортой байдлыг анхаарч үзэх хэрэгтэй байгаа талаар АН-ын бүлгийн гишүүдтэй байр сууриа солилцсон байна. УИХ дахь Ардчилсан намын бүлгийн гишүүдийн зүгээс төрийн албыг арилжааны хэрэгсэл болгож буй талаар ярилцсан "60 тэрбум"-ын гэж нэрлээд буй асуудлаар тодорхой мэдээлэл өгөхийг Төрийн Албаны Зөвлөлд даалгалаа. Бүлгийн хуралдааны эцэст Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай" УИХ-ын тогтоолын төсөлтэй холбоотойгоор ажлын хэсэг байгуулж, УИХ-ын гишүүн З.Нарантуяа эдгээр ажлын хэсгийн ахлагчаар ажиллахаар болжээ. Харин УИХ дахь МАН-ын бүлэг өчигдрийн ээлжит хуралдаанаараа Монгол Улсын 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг хэлэлцэж, Сангийн сайд Б.Чойжилсүрэнгийн мэдээллийг сонсчээ. Тус намын бүлэг үдээс өмнө хуралдаж түр завсарласан бөгөөд үдээс хойш үргэлжлүүлэн хуралдаж сэтгүүлчдэд мэдээлэл хийсэнгүй.

> Түүнчлэн сүүлийн үед төрийн албанаас 22365 хүн халагдсан. Үүнээс 3000 гаруй хүн тэтгэвэрт гарсан тухай Төрийн Албаны Зөвлөлийн дарга энэ үеэр мэдээлэл өгсөн аж. УИХ-аар хэлэлцэж буй Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөр төрийн албаны тогтвортой байдлыг анхаарч үзэх хэрэгтэй байгаа талаар АН-ын бүлгийн гишүүдтэй байр сууриа солилцсон байна.

## Өрхийн орлого өссөн ч улсын төсөв алдагдалтай гарчээ

Г.ГАНЧИМЭГ

Үндэсний статистикийн хороо /ҮСХ/-ноос энэ оны эхний дөрвөн сарын нийгэм, эдийн засгийн статистик үзүүлэлтийг танилцууллаа. Энэ өвөл, хавар Монгол Улсад 22 мянга 790 шинэ иргэн мэндэлжээ. "Хүн нэмэхээр хүнс нэмнэ" гэдэг. Тэгвэл манай улсад одоогоор хөдөлмөрийн насны нэг сая 262 мянга 300 иргэн байгаа юм. Үүний 770 гаруй мянга нь нийслэлд, 480 орчим мянган иргэн хөдөө, орон нутагт амьдарч байгааг Статистикийн байгууллагын тоон мэдээнд дурьдсан байсан юм. Дээрх иргэдийн 45 мянга 700 нь албан ёсоор ажилгүй хэмээн бүртгүүлжээ. Манай улсын эдийн засгийн нөхцөл байдал хүндэрч, хямралын шинжтэй байгаа ч өрхийн дундаж орлого өссөн дүнтэй гарсан анхаарал татахуйц сонирхолтой тоо ч энд байгаа юм. Сар бүр ҮСХ-оос гардаг статистик судалгаагаар энэ удаад өрхийн дундаж орлогыг 893 мянга 300 төгрөг байна гэж тооцоолжээ. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс 43 мянга 900 төгрөгөөр өссөн үзүүлэлт юм. Гэтэл өрхийн орлого нь өссөөр байгаа Монгол Улсын нэгдсэн төсөв 285 тэрбум таван сая төгрөгийн алдагдалтай гарчээ. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс 378 тэрбум нэг сая төгрөгөөр буурсан үзүүлэлт гэнэ. Өөрөөр хэлбэл, албаны хүний үгээр бол улсын төсвийн алдагдалыг бууруулж буй аж. Юутай ч энэ оны эхний дөрвөн сард улсын төсвийн орлого хоёр их наяд 94 тэрбум 400 сая төгрөг байжээ. Харин зарлага нь хоёр их наяд 379 тэрбум 800 сая төгрөг болсон байна. Дараагийн хүн бүхэнд хамаатай нэг тоо бол инфляци буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ. Энэ тоо өсчээ. Өнгөрсөн сард энэ тоо өмнөх гуравдугаар сарынхаас 1.3 хувиар нэмэгдсэн байна. Харин өмнөх оны эцсээс 4.8 хувиар өссөн аж. Бараа, үйлчилгээний үнэ ийнхүү өсөхөд тээврийн хэрэгслийн худалдаа болон махны үнэ нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлаа дагаад мөнгөний нийлүүлэлт, чанаргүй зээл ч өсөх хандлагатай байгаа аж. Өнгөрсөн дөрөвдүгээр сард мөнгөний нийлүүлэлт 12 их наяд дөрвөн тэрбум төгрөг болж, өмнөх гуравдугаар сарынхаас 220 тэрбум 900 сая төгрөгөөр өсчээ.

MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Б.ӨНӨРТОГТОХ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг:
Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/.
2 давхар. 209, 211 тоот

"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ӨӨР ӨНЦӨГ

## Н.Энхбаяр хэнд боломж олгох вэ

Б.ТОГТОХ

Намын дарга нь Ерөнхийлөгчийн сонгуулийн шалгуурт бүдэрснээр МАХН-ын улстөрчдийн дунд Ерөнхийлөгчид өрсөлдөх марафон эхэлжээ. Тус намынх биш атлаа дэргэд нь давхиж яваад өрсөлдөх хүсэлтэй улстөрчид ч чамгүй олон байгаа гэх. Тэдний нэг нь УИХ-ын гишүүн асан С.Ганбаатар. Улс төрд анх танигдахдаа бие даагч гэх тун гоё автортай гарч ирж байлаа. Төд удалгүй Хөдөлмөрийн үндэсний нам байгуулж, даргаар нь очсон ч тамганы маргаанаас болж хөөгдөх шахам гарсан нь худлаа биш. 2016 оны сонгуулиар өвдөг шороодож хэсэгтээ л нам гүм байсан тэрбээр Ерөнхийлөгчийн сонгуулийн дуулианаар хэлд орсон. Улмаар МАХН-ын даргын дэргэд ойр шадарлах болж, өчигдөр гэхэд л МАХН-ын өмнөөс хэвлэлийн хурал хийлээ. Авлигын эсрэг тууштай тэмцдэг хэмээн өөрийгөө магтдаг С.Ганбаатар гэх улстөрч "авлигын загалмайлсан эцэг" гэгддэг Н.Энхбаярыг өмгөөлөөд сууж байгааг харах цаг ирдэг л юм байна. Улс төрд нөхөрлөл гэж үгүй. Мөнхийн эрх ашиг гэж бий гэдгийг л энэ хоёр эрхэм яруу тодоор харуулав. Түүнчлэн, МАХН-аас Ерөнхийлөгчид нэр дэвших хүсэлтээ гэдгээ Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн С.Нарангэрэл илэрхийлжээ. Мөн УИХ-ын Тамгын газрын дарга асан Ц.Шаравдоржид ч ийм хүсэл байгаа гэдгээ нуугаагүй. Тэгэхээр Н.Энхбаяр уу, эсвэл өөр хүн үү гэдэг нь маргаашнаас өмнө тодорхой болох нь. МАХН-ын хийх нүүдэл ямар байхаас АН-ын нэр дэвшигч үү, эсвэл МАН-ын нэр дэвшигч ялах уу гэдэг тодорхой болно. Мэдээж хоёр том улс төрийн хүчний дунд л өрсөлдөөн явна. МАХН-ын нэр дэвшигчид Ерөнхийлөгчид өрсөлдсөн гэдэг намтар л чухал байх биз ээ. Хэрвээ Н.Энхбаяр өөрөө нэр дэвшвэл АН-ын нэр дэвшигчид том боломж гарч ирэх байв. Харин өөр нэр дэвшигч өрсөлдвөл хэн хэнийх нь саналаас адилхан хувааж МАН-ын өрсөлдөгч илүүрхэх магадлалтайг улс төр судлаачид онцолж байгаа юм. Н.Энхбаяр өөрөө л нэр дэвшихгүй бол МАН ялалт байгуулна. Энэ тохиолдолд ашиггүй гэдгийг мэдэж байгаа нь тодорхой. Үнэн худлыг хэлэхэд эрт байна. Н.Энхбаяр ямар шийдвэр гаргахаас хоёр өрсөлдөгчийн санал хаашаа хуваагдах вэ гэдэг нь тодорхой болно. Мэдээж эр хүний дотор эмээлтэй хазаартай морь бий гэгчээр өстөн дайсан болох МАН-ынханд боломж олгохгүй гэдгээ Н.Энхбаяр мэдэхийн дээдээр мэдэж байгаа нь дамжиггүй.

## МАХН-ын гишүүд пүрэв гарагт жагсана




*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

Г.ЧИМЭГ

СЕХ 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуульд МАХН-аас нэр дэвшигч Н.Энхбаярыг бүртгэхээс татгалзсан нь хууль бус гэж үзэж буйгаа тус намын Удирдах зөвлөл, хамтран ажилладаг иргэний хөдөлгөөн болон нам бусчуудын төлөөлөл өчигдөр Үндэсний мэдээллийн төвд зарласан хэвлэлийн хурлын үеэрээ мэдэгдлээ. Тухайлбал, МАХН-ын дэд дарга Ц.Оюунбаатар "Энэ удаагийн Ерөнхийлөгчийн сонгууль Монголын улс төр, эдийн засгийн олигархиуд, МАНАН бүлэглэлийн бохир улс төрийн тогтолцооноос гарч, монголчууд байгалийн баялагтаа эзэн суух чухал хариуцлагатай гэдгээрээ онцлог юм. Мөн Монголын ирээдүй, тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдалд аюул учирч байна. Төрийн албан тушаалд тодорхой тариф тогтоож, эрх мэдлийг худалдан 60 тэрбум төгрөг босгож сонгуульд бэлдэж байгаа. Гадаад, дотоодоос хууль бусаар бохир мөнгө, зээл тусламж авчран энэ сонгуулийг мөнгөний сонгууль болгох гэж байгааг ард түмэн, шударга иргэд, МАН, АН, МАХН-ын жирийн гишүүд, нам бусчууд бүгд эсэргүүцнэ гэдэгт найдаж байна. Бид цаашид СЕХ-ны хууль зөрчсөн шийдвэрийг зохих байгууллагуудаар хянуулна" хэмээлээ. Харин СЕХ хэтэрхий ерөнхий хариулт өгч, бүртгэхгүй гэдгээ хуулийн дагуу тайлбарлаж чадаагүй гэдгийг Гавьяат хуульч Ц.Шаравдорж онцоллоо. Мөн МАХН-ын дарга Н.Энхбаярыг ил тод дэмжих болсон экс гишүүн С.Ганбаатар ч энэ өдрийн хэвлэлийн хуралд оролцов. Тэрбээр, "2017 оны Ерөнхийлөгчийн сонгуульд МАХН-аас нэр дэвшигч Н.Энхбаяр яллаа. Үүнийг МАНАН-ынхан хүлээн зөвшөөрчихлөө. Тэдний ялах ганц арга нь хуулийг гуйвуулж, сонгуульд оруулахгүй байх явдал юм. Эх орончдын эвсэл, иргэний нийгмийн байгууллагууд МАХН-тай хамтран 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулахын төлөө ажиллаж байгаа. МАНАН-ын эсрэг хийж буй энэ үйлдэл нь бид өөрсдийнхөө төлөө бус ард иргэдийнхээ төлөө юм. Өнөөдөр МАНАН зөвхөн гурван сая хүний сонгох, сонгогдох эрхэд халдсан юм биш. Тэдний дээр байгаа ОУВС, Рио Тинтогийн удирдлагууд Монгол Улсын төр барих эрхэд халдлаа. Үүнтэй холбогдуулж, бид энэ сарын 18-ны 11.00 цагт нийт ард иргэдээ уриалж жагсаал зохион байгуулна. Эрх баригчдын бохир булхай, зүй бус үйлдлийг илчлэн, хуулийн дагуу эрхээ эдэлнэ. Шударга бус үйлдлийн эсрэг ард түмнээ нэгдэхийг хүсч байна" гэв.

ҮЗЭЛ БОДОЛ

# Орхон аймаг ТЭРГҮҮЛЖ, Говь-Алтай СҮҮЛ МУШГИВ




**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Тэгвэл XXI зуунд дэлхий дахинд өрсөлдөх чадварын суурь үзүүлэлт инновацид тулгуурласан эдийн засаг руу чиглэгдэж буй. Гэхдээ дэлхийтэй хөл нийлүүлэхийн тулд бид хүссэн хүсээгүй өрсөлдөх чадварын тухай ярьж, түүний шалгуур үзүүлэлтийг хангах явдал. Үүний тулд Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийг 2010 онд байгуулж, тус төвөөрөө дамжуулан хөдөө, орон нутгийн өрсөлдөх чадварын тайланг гаргах болсон. Энэ жилээс тус төв үйл ажиллагааныхаа цар хүрээг тэлж, нийслэл, дүүргүүдийн өрсөлдөх чадварт судалгаа хийж, тайланг олон нийтийн хүртээл болгож эхэлжээ.

Тэдний гаргасан тайлан шийдвэр гаргагчид бизнес эрхлэгчид, судлаачдыг бодит мэдээллээр хангахаас гадна өдрөөс өдөрт улам бүр мэдрэгдэж байгаа хот, хөдөөгийн ялгаа нийгэмд хэрхэн нөлөөлж байгаад бодит дүгнэлт хийх боломжийг олгож байна. Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан гараад удаагүй байна. Тодруулбал, Монгол Улс 21 аймгаа эдийн засгийн чадавхи, хүн амын амьжиргааны төвшин, хөдөлмөр эрхлэлтийн байдал, инстутын тогтолцоо, бизнесийн эрх зүй, бизнесийн орчин, нийгмийн тогтолцоо, эрүүл мэнд, боловсрол гэхчилэн хөгжлийг тодорхойлогч хүчин зүйлүүдэд судалгаа хийн үзүүлэлтээр нь жагсаасан байна. Энэхүү тайланг аймаг бүрийн давуу болон сул тал байгааг эдийн засгийн тамир тэнхээ, засаглалын үр ашиг, бизнесийн үр ашиг, болон дэд бүтэц гэсэн үндсэн дөрвөн хүчин зүйлийн 180 гаруй шалгуур үзүүлэлтээр харьцуулан гаргажээ. Түүнчлэн өмнөх жилтэй харьцуулахад хамгийн их өссөн болон буурсан 20 үзүүлэлтийг жагсаажээ.

Эдийн засгийн өрсөлдөх чадвараар Орхон аймаг тэргүүлж, Дархан-Уул, Сүхбаатар, Дорноговь, Сэлэнгэ, Говьсүмбэр, Өвөрхангай аймаг айргийн тавд бичигдсэн бол Архангай, Дундговь, Говь-Алтай сүүл мушгисан байх жишээний. Дорноговь, Өвөрхангай, Баян-Өлгий аймаг 2016 онд өрсөлдөх чадварын бүхий л үзүүлтэд өмнө авсан оноогоо ахиулж, эхний таван байрын болзлыг хангасныг судалгааны төвийнхөн онцлон тэмдэглэж, түүнийгээ улбар шар өнгөөр тодотгож өгсөн харагдана. Улбар шарын бүлгийг толгойлсоор байгаа Орхон аймгийн хувьд үндсэн дөрвөн үзүүлэлтэд бүгдэд нь 100 оноо авчээ. Харин удаалж яваа Өмнөговь аймгийн эдийн засгийн тамир тэнхээ-95.09, засаглалын үр ашиг -93.62, бизнесийн үр ашиг-98.34, дэд бүтэц-98.1 оноо авчээ. Дархан-Уул аймгийн тухайд үндсэн дөрвөн хүчин зүйлийн 180 гаруй шалгуурын ихэнхэд нь 94 –өөс дээш оноо тухайлбал, эдийн засгийн чадавхид -94.34, хоёр дахь нь 94.43, гуравдугаар үзүүлэлтэд 97.97, дөрөв дэхэд 96,33 оноо авсан байх жишээний. Дархан-Уул аймаг хүн амын амьжиргааны түвшин, бүтээн байгуулалт, технологийн шинэчлэлээрээ ийнхүү эхний гуравт багтав. Дорноговь, Сүхбаатар аймаг өнгөрсөн жил бүтээн байгуулалтаараа улсад тэргүүлсэн нь өрсөлдөх чадварт нь эерэгээр нөлөөлж, авсан оноонызоо хувьд бараг л тэнцэх шахсан байх юм. Эдийн засаг хямарсан энэ цаг дор дорноговьчууд нөөц бололцоогоо ашиглан иргэдийнхээ нийгмийн асуудлыг нэн даруй шийдэх зүйлийн жагсаалтад багтаасны үр дүнд амжилтынхаа шатыг нэгээр ахиуллаа. Гэр хороолол дахь явган хүний зам, талбай хийгээд дэд бүтцийн асуудлыг зохих хэмжээнд шийдсэн. Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлж байгаа байдал, Сайншанд хотноо тун удахгүй ашиглалтад орох 240 айлын орон сууц зэрэг нь эдийн засгийн өрсөлдөх чадварын шалгуур үзүүлэлтэд тэргүүлэх боломжийг олгосон байна. Сэлэнгэчүүд хүн амын амьжиргааны төвшингээрээ эдний араас шил даран орж иржээ. Ер нь Сэлэнгэ аймаг өрхийн аж ахуй эрхлэгчдээ маш сайн дэмжиж буй. Хүн амынх нь чаддаг ганц зүйл нь ч байж мэднэ. Төрд алба хаших уу, хувиараа бизнес эрхлэх үү гэвэл хувийн хэвшлийг илүүд үзэх энэ аймгийн өрх бүр хашаандаа төмс, хүнсний ногоо тариалж, гахай, тахиа тэжээдэг. Тэр хэрээр өрхийн орлого жилээс жилд нэмэгдэж байдаг юм. Өвөрхангай аймгийн тухайд хөгжлийн гарцаа жижиг дунд үйлдвэрлэл, бизнесийн орчинг сайжруулах явдал гэж тодорхойлсон нь хамгийн оновчтой шийдэл байсан хэмээн дүгнэж болно. Тэгээд ч мал сүргийн тоогоор улсад сүүлийн хэдэн жил тэргүүлсээр ирсэн. Мал, малын гаралтай түүхий эд, тодруулбал, ямааны ноосоос орж ирэх ашгийг орон нутагт шингээж үлдэх цаашлаад нэмүү өртөг шингээх тал дээр илүүтэй анхаарч байгаа нь өвөрхангайчуудад ийн өгөөжөө өглөө. Мах боловсруулах болон ноос, ноолуур боловсруулах үйлдвэрээ энэ жилдээ багтаан ашиглалтад оруулах аваас ирэх жил хамгийн өндөр оноо авахгүй гэх газаргүй. Сүхбаатар аймгийн хувьд засаг захиргааных нь үйл ажиллагаа тогтворгүй байгаа ч өнгөрсөн 2012-2016 оны хооронд хийж бүтээсэн амжилтаараа айргийн тавд багтсан хэрэг. Гэр хорооллын дахин төлөвлөлтийг Сүхбаатарчууд л жинхэнэ утгаараа хийж чадсан байдаг. Говьсүмбэр сүүлийн найман жилд танигдахгүй болтлоо өнгө төрхөө өөрчилж, хөгжих төрхөндөө хэдийнэ орсон аймаг. Эл амжилт нь Чойрынхныг эдийн засгийн өрсөлдөх чадвартай болохыг баталсан биз ээ.










*Аймгуудын өрсөлдөх чадварыг графикаар харуулав.*


BUSINESS

БАНКНЫ ШИНЭ ҮЙЛЧИЛГЭЭ

## "ХААН БИЗНЕС" ҮЙЛЧИЛГЭЭ ШИНЭЭР ГАРЛАА

*2017 оны 05-р сарын 15-ны өдөр, Даваа гараг, Улаанбаатар хот.*

ХААН Банк нь иргэд харилцагчид, байгууллага, жижиг дунд бизнес эрхлэгчдэд банкны үйлчилгээг түргэн шуурхай, найдвартай хүргэж ирсэн билээ.

Энэ удаад жижиг дунд бизнес (ЖДБ) эрхлэгчдийхээ хэрэгцээ шаардлагад нийцсэн бүхий л үйлчилгээг нэгтгэсэн "ХААН Бизнес" үйлчилгээг шинээр гаргаж, харилцагчиддаа хүргэж эхэлсэн болохыг дуулгахад таатай байна. Энэхүү шинээр гаргаж буй "ХААН Бизнес" үйлчилгээ нь ЖДБ эрхлэгчдэд зориулсан бүх төрлийн дансны үйлчилгээ, төлбөр тооцоо, зээлийг тусгай салбараар дамжуулан хүргэж буйгаараа анхдагч үйлчилгээ юм. Таны бизнесийн амжилтын төлөө уриатай "ХААН Бизнес" үйлчилгээг сонгосноор ЖДБ эрхлэгчдэд зориулсан банкны цогц үйлчилгээ, бүх төрлийн зээлийг тусгайлсан бизнес төвүүд, салбаруудаар дамжуулан авах онцгой боломжийг олгож байна.

Эрхэм ЖДБ эрхлэгч та бүхэн "ХААН Бизнес" үйлчилгээнд нэгдэж, зөвхөн танд үйлчлэх тусгай бизнес төв болон тусгай салбаруудаар дамжуулан тав тухтай тохилог орчинд банкны үйлчилгээг авч, бизнесээ өргөжүүлээрэй. Мөн "ХААН Бизнес" үйлчилгээгээр мэргэшсэн харилцааны менежерүүд танд зөвлөн таны бизнесийн хэрэгцээ шаардлагад нийцсэн банкны бүх төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгож таны бизнесийн төлөө ажиллах болно.

Цаг зав багатай бизнес эрхлэгч танд найдвартай, эргэх холбоотой банкны цогц үйлчилгээ эсхүл бизнесээ бүх чиглэлээр өргөжүүлэх хэрэгцээ шаардлага байвал 333030 дугаар болон Khanbusiness@khanbank.com хаягт хандан "ХААН Бизнес" үйлчилгээний харилцагч болоорой. Та эдгээр хаягаар бидэнтэй холбогдож, өөрийн бизнесийн хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг авч, санал хүсэлтээ ирүүлээрэй.

Та бүхэн "ХААН Бизнес" үйлчилгээтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг info.khanbank.com хуудаст хандан аваарай.





Дугаарын 60 мөр

## Хөхний сүү хуульчлахаас өөр хийх ажил алга уу

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Тэр дундаа 0-6 сартай хүүхдийг зөвхөн эхийн сүүгээр хооллохыг хуульчилж өглөө. Хэрвээ нэмэлт бүтээгдэхүүн өгөх шаардлагатай гэж үзвэл зөвхөн эмчийн бичгээр авна. Томоохон худалдааны төвүүд зарахгүй бөгөөд чанарын шаардлага хангасан нэмэлт бүтээгдэхүүнийг эмийн сангууд эмчийн бичгээр зарна хэмээн хуульчлав. Хэрвээ хууль зөрчвөл эх торгууль төлнө. Нэг талаараа хяналтгүй асуудлыг цэгцэнд оруулж байгаа нь сайн хэрэг. Гэвч энэ хуулийг дагалдаж гарах сөрөг талыг эрхэм сайд бодолцож үзээгүй нь илт байгаа юм. Хэн ч төрсөн үрээсээ хөхний сүүгээ харамлахгүй нь тодорхой. Хөхний хэлбэр алдагддаг гэх мэтээр урлаг, соёлын мэргэжилтэй бүсгүйчүүд хүүхдээ хөхүүлэхээс татгалздаг гэдэг ч үнэн худлыг хэн ч батлаагүй. Нөгөөтэйгүүр, эх нь хүүхдээ хөхүүлэхгүй байх шалтгаан дэндүү олон. Орчин үед эмч, эмнэлгийн ажилтнууд төрөхийн хүндрэл гаргахгүйн тулд бага зэргийн хүндрэлтэй төрөх эхчүүдийг хийсвэр хагалгаагаар төрүүлдэг болсон. Гэтэл дахин төрсөн болон анхан төрж байгаа эхчүүдийн хөхөнд сүү орох нь харилцан адилгүй байгаа. Дийлэнх нь гурав хоногийн дараагаас сүү орж эхэлдэг. Уургаа амлуулж өдөржин хөхүүлдэг ч дусал ч сүү гарахгүй байх тохиолдол олон байдгийг эрхэм сайд мэддэг байлтай. Эдгээр эхчүүд хэрхэх вэ. Хүүхдээ өдөржин уйлуулж харангадуулах хэрэг үү. Эмч зөвхөн халдвартай болон сүү багатай ээжүүдэд нэмэлт бичиж өгнө хэмээн гүрийчихвэл яах билээ. Тэр гурван хоногт өөрөө оёдолтой атлаа хүүхдээ тэвэрч яв хэмээн загнадаг эмч нар бишгүй олон бий. Хуучин цагт хүүхэд нь өвчтэй болон ямар нэг шалтгаанаар эмчлүүлж байгаа ээжүүдийг дамжуулан хөхүүлж болдог байсан ч орчин цагт тийм зүйл байхаа больсон. Хөхний сүүгээр дамжиж халдвар авдаг, эс бөгөөс хүүхэд халдвартай байх магадлалтай хэмээн бусдын хүүхдийг хөхүүлдэг ээжүүд ч багассан. Тиймээс аргагүйн эрхэнд ээжүүд хүүхдээ харангадуулахгүйн тулд нэмэлтээр угждаг нь худлаа биш. Харамсалтай нь үүнийг хуулиар хориглочихлоо. Хуулийг дагаад нэмэлт бүтээгдэхүүний бизнес далд хэлбэрт шилжинэ. Эмчээс нэмэлт бичүүлж авахын тулд ээжүүд авлига өгч эхлэх вий. А.Цогцэцэг сайдын хэлсэнчлэн хөхний сүүгээр хүүхдээ хооллох хүсэлгүй ээжүүд 60 хувьд хүрсэн бол зах зээл хангалттай байна гэсэн үг. Тиймдээ ч хөхний сүүний нэмэлт бүтээгдэхүүнийг харин ч хууль бусаар зарах, авлига авч бичиж өгөх зэрэг асуудал гарч л таараа. Аливаа зүйлийг хуулиар хориглох тусмаа нууц далд хэлбэрт шилждэг тэр л жишиг хэрэгжих нь ээ. Амьдралд нийцдэггүй, тооцоо судалгаагүй хуулийн тоог нэгээр нэмээд л өнгөрөх нь тодорхой байна. Дэлхий дахин хүүхдээ хөхний сүүгээр хүүхдээ хооллохыг дэмждэг. Гэвч манайх шиг хатуу хуульчилдаг нь юу л бол. Эрүүл саруул хүүхэд өсгөх үү, эсвэл давжаа биетэй хүүхэдтэй байх уу гэдгээ ээжүүд ялгаж салгадаг л байлтай. Миний эргэн тойронд лав тийм харгис сэтгэлтэй ээж алга. Тиймээс төрсөн үрээ юугаар хооллоход биш тэднийг эмнэлгийн үйлчилгээг хүнд суртал, авлигагүй авахад салбарын сайд маань анхаарвал зүгээрсэн. Эмнэлгийн үйлчилгээ авч чадахгүйгээс, эрүүл мэндийн зөвлөгөө хангалттай биш байгаагаас л ээжүүд хүүхдээ буруу хооллож, рахиттай, давжаа биетэй болгож байгаа нь худлаа гэж хэлэхгүй биз ээ. Санаа нь зөв ч байгаа буруу сонгочихсон гэдгээ А.Цогцэцэг сайд ойлгох биз ээ.

## ДЭЛХИЙ

# Өмнөд Солонгосын шинэ Ерөнхийлөгч “ТҮРГЭН АВАВ”




**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Тэгвэл үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан Ерөнхийлөгчийн ажлаа аваад тав хоножбуй БНСУ-ын төрийн тэргүүн Мүн Жэ Ин Япон руу тусгай элч төлөөлөгчдөө илгээгээд байна. Тэдний ярианы гол сэдэв нь Солонгосын хойгийн өнөөгийн нөхцөл байдал байх гэнэ.

БНАСАУ энэ сарын 14-нд шинэ загварын баллистик пуужин харван туршсан байдаг. Тэгвэл энэ үйл явдлаас ердөө нэг хоногийн дараа Ерөнхийлөгч Мүн тусгай элчээ Япон руу илгээжээ. Зарим хэвлэлд бичсэнээр хурцадмал байдал үүссэн өнөө үед Япон, БНСУ-ын харилцаа нягт уялдаа холбоотой байхыг бататгах алхам аж. Мүн Ерөнхийлөгчийн тангараг өргөснийхөө маргааш нь Японы Ерөнхий сайд Шинзо Абэтэй утсаар ярьж, “аль болох яаралтай хоёр талт уулзалт хийх бодолтой” байгаагаа илэрхийлсэн байна. Тэдний уулзалт ч төд удахгүй товлогдох нь. Түүнчлэн, Хөх ордны тусгай элч нар зөвхөн Япониор тогтсонгүй. Солонгосын хойгтой холбоо бүхий АНУ, БНХАУ, ОХУ, Герман зэрэг бусад улс орон руу ч айлчлахаар болжээ.

Тэд төрийн өндөр албан тушаалтнуудтай уулзалт хийж, БНСУ-ын шинэ Засгийн газрын бодлого чиглэл, харилцаа холбоогоо хэрхэн улам гүнзгийрүүлэн хөгжүүлэх талаар яриа хэлэлцээр хийх юм байна.

БНСУ-ын тусгай багт Солонгосын “Joongang Ilbo” сонины эрхлэгч, АНУ-д суух БНСУ-ын Элчин сайд асан Хон Сук Хюн багтаж байгаа аж. Тэрбээр АНУ-д айлчлах тусгай элчээр ажиллах гэнэ. Харин Ерөнхий сайд асан И Ха Чан БНХАУ-д айлчлах багийг ахлах юм байна. Харин УИХ-ын дэд дарга асан, Ардчилсан намын хуулийн зөвлөх Мүн Хэ Сан Японд, Инчён хотын захирагч асан Сун Ян Гил ОХУ-д айлчлах бол шинэ Ерөнхийлөгч Мүн Жэ Иний эдийн засгийн бодлогын зөвлөх Чо Ён Жэ Герман руу томилогджээ.

Хойд Солонгос ням гарагт пуужин туршсан байдаг. Харин өчигдөр тус улсын Засгийн газраас албан ёсоор мэдээлэл хийж, шинэ төрлийн дунд зайн тусгалтай баллистик пуужинг амжилттай хөөргөн туршсанаа мэдэгдсэн юм. Тодруулбал, тус улс “Hwasong12” гэх төрлийн пуужин туршсан бөгөөд энэ нь шумбагт хөлөг онгоцноос харвадаг дунд зайн тусгалтай баллистик пуужингийн шинэчилсэн хувилбар юм байна. Хойд Солонгосоос хийсэн мэдэгдэлд “удирдагч Ким Жон Уны тушаалаар баллистик пуужинг амжилттай туршсан. Хүчтэй бөгөөд том цөмийн цэнэгт хошуу тээх боломжтой шинэ баллистик пуужингийн техникийн онцлог үзүүлэлтүүдийг бататган шалгахын тулд туршилтыг хийсэн” гэжээ. Пуужин 2111 км-ийн өндөрт хөөрч, хөөргөсөн газраас 787 км-ийн зайд тэнгист байсан байнд оновчтой туссан байна.

Пхеньян өнгөрсөн жилийн нэгдүгээр сараас хойш цөмийн зэвсгийн туршилт хоёр удаа, баллистик пуужингийн туршилтыг хэдэн арван удаа хийж, цөмийн зэвсгийн хөгжүүлэлтээ үргэлжлүүлсээр байгаа юм.

## 101 настай хөгшин дээд амжилтыг эвджээ

Их Британийн иргэн, 101 настай хөгшин 4600 метрийн өндрөөс үсрэлт хийж, дэлхийн дээд амжилтыг шинэчлэн тогтоожээ. Тэрбээр хамгийн өндөр насандаа өдий хэрийн өндрөөс үсэрсэн анхны хүн болж байгаа юм байна. Их Британийн баруун өмнөд этгээдийн Сомерсетын иргэн 101 настай Брисон Уильям Вердун Хайес энэ амжилтыг эвджээ. Тэрбээр энэ сарын 14-нд Дебон хот дахь нислэгийн талбайд тусгай хувцас хэрэглэл өмсч, бага оврын нисэх онгоцонд суун дээш хөөрсөн байна. Улмаар 4600 метрийн өндөрт гарсныхаа дараа зааварлагчийнхаа хамт үсэрчээ. Үүгээр зогсохгүй энэхүү амжилтыг эвдэхэд өвөө, хүү, ач, гуч гэсэн нийтдээ дөрвөн үеийн төлөөлөл хамтдаа оролцсон гэдгээрээ онцлог юм байна. Хайес газарт шүхрээр буухад гэр бүлийнхэн нь алга ташин баяр хүргэж байжээ. Өмнө нь энэ амжилтыг Канадын иргэн эзэмшиж байсан байна. Тэрбээр 2013 онд хамгийн өндөр насандаа өндрөөс үсрэлтийн шинэ амжилтыг тогтоохдоо 101 нас гурван хоногтой байсан гэнэ. Харин Хайесын тухайд 101 нас 38 хоногтой аж. Ийнхүү өмнөх амжилтыг 35 хоногоор шинэчлэн тогтоосон байна. Брисон Уильям Вердун Хайес 100 насныхаа төрсөн өдрөөр хамгийн анхны үсрэлтээ хийж байжээ. Ямартай гиннесийн амжилтыг шинэчлэн тогтоосныхоо дараа тэрбээр “Чадвал 102, 103 насандаа ч өндрөөс үсрэхийг хүсч байна” хэмээн ярьсан байна.

## “Нэг бүс, нэг зам” олон улсын форум өндөрлөлөө

БНХАУ-ын Бээжин хотноо эхэлсэн “Нэг бүс, нэг зам” олон улсын хамтын ажиллагааны дээд хэмжээний уулзалт өндөрлөлөө. Хуралд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин, Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат, Туркийн Ерөнхийлөгч Ресеп Тайип Эрдоган, Филиппиний Ерөнхийлөгч Родриго Дутерте нарын 29 улс орны төр, Засгийн газрын тэргүүн, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерриш, ОУВС-гийн захирал Кристин Лагард, Дэлхийн банкны Ерөнхийлөгч Жим Ён Ким нарын 70 гаруй олон улсын байгууллагын томоохон албан тушаалтнууд оролцсон юм. Үүнээс гадна 130 орны 1500 гаруй төлөөлөгч оролцжээ. БНХАУ-ын дарга Си Зиньпин “Нэг бүс, нэг зам” санаачилгыг анх 2013 онд гаргаж, хэрэгжүүлж эхэлсэн байдаг. Тэгвэл түүнээс хойшхи анхны томоохон хэмжээний уулзалт нь энэ удаа болж буй гэдгээрээ онцлог болсон. Хурлын нээлтийн үеэр Си Зиньпин боомт, төмөр зам, автозам, аж үйлдвэрийн цогцолбор зэрэг томоохон дэд бүтцийн сүлжээг байгуулахад 12.4 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийхээ зарласан. Тэгвэл хуралд оролцсон төлөөлөгчид энэ удаагийн уулзалтыг ихээхэн үр дүнтэй болсныг онцолж байна. Их Британийн Сангийн сайд Филип Хаммонд “Их Британийн Засгийн газар “Нэг бүс, нэг зам” санаачилгыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд бүхий л холбоотон улсуудтайгаа хамтран ажиллах болно” хэмээн мэдэгджээ. Гэхдээ энэ удаагийн уулзалтаас сэтгэл дундуур үлдсэн улс орны удирдагчид ч байгаа гэнэ. Тухайлбал, Германы Эдийн засаг, эрчим хүчний сайд Брижит Зиприс хөрөнгө оруулалттай холбоотой тендерийг ялгаварлан гадуурхалтгүй, ил тод байдлаар явуулахыг шаардсан бол Энэтхэг “Нэг бүс, нэг зам” санаачилгын хүрээнд БНХАУ-ын баруун хойд хэсгийг Арабын тэнгистэй холбох Хятад-Пакистаны эдийн засгийн коридорт сэтгэл дундуур байгаагаа илэрхийлээд амжжээ. БНХАУ-ын дарга Си Зиньпиний “Нэг бүс, нэг зам” санаачилга биелэлээ олсон тохиолдолд дэлхийн хүн амын 60 хувь буюу 65 орныг хамрах бөгөөд ингэснээр тус улсын ДНБ-ий хэмжээ дэлхийн гуравны нэгийг эзлэх юм.

Ийнхүү амжилт бүтээл, үр дүн арвинтайгаар “Нэг бүс, нэг зам” олон улсын хамтын ажиллагааны дээд хэмжээний хурал хаалтаа хийлээ.


## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : **2017 оны 05 дугаар сарын 16-ны өдөр**
Тендер шалгаруулалтын нэр: **Багахангай дүүрэг, 2 дугаар хорооны цогцолбор барилгаас 12 дугаар байр хүртэлх шинэ зам**
Тендер шалгаруулалтын дугаар: **НХААГ-17/0112**

**Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар** эрх бүхий тендерт оролцогчдоос: **Багахангай дүүрэг, 2 дугаар хорооны цогцолбор барилгаас 12 дугаар байр хүртэлх шинэ зам** ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах цахим тендер ирүүлэхийг урьж байна.
Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.
Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50 000 (тавин мянга)** төгрөгийг банкны меркантын системийг ашиглан төлсөн байх ёстой.
Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Борлуулалтын хэмжээ:
**Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 онуудын борлуулалтын орлогын дундаж нь төсөвт өртгийн үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй байна.**
2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:
**Төсөвт өртгийн үнийн дүнгийн 30 хувиас доошгүй байх.**
3. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо:
**Сүүлийн 2 жилийн буюу 2015, 2016 онуудын аль нэг жилийн хугацаанд төсөвт өртөгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байна.**
4. Уг ажлыг гүйцэтгэхэд тусгай зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай эсэх: **“тийм”**
3.7.4.1 ЗЗА-1 Бүх төрлийн замын засварын ажил эсвэл
2.8.6. Хатуу болон хайрган хучилттай зам засварлах ажлыг гүйцэтгэх зөвшөөрөлтэй байх.
5. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:
**Сүүлийн 2 жил (2015, 2016 он) -ийн эцсийн санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлнэ.**
6. Тендерийн баталгааны үнийн дүн:
**“2,550,000 төгрөг” /хоёр сая таван зуун тавин мянга/ төгрөгийн тендерийн баталгаа ирүүлнэ**.

Цахим тендерт оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулна.

Тендерийг **2017 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 09:00 цагаас** өмнө цахим системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 09:30 цагт** Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын тендерийн нээлтийн 1012 тоот өрөөнд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.
Дотоодын давуу эрх тооцно.

**Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.**
**Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Багатойруу-15, Самбуугийн гудамж, Нийслэлийн Засаг захиргааны IV байр, 10 давхарт Утас: 75757810,**

**Цахим хаяг: www.ub-procurement.mn, www.tender.gov.mn**



## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : **2017 оны 05 дугаар сарын 16-ны өдөр**
Тендер шалгаруулалтын нэр: **Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Гал унтраах ангийн урдуур Аварга их сургууль хүртэлх авто зам, шинэ холбоос замын ажил**
Тендер шалгаруулалтын дугаар: **НХААГ-17/0111**

**Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар** эрх бүхий тендерт оролцогчдоос: **Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Гал унтраах ангийн урдуур Аварга их сургууль хүртэлх авто зам, шинэ холбоос замын** ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах цахим тендер ирүүлэхийг урьж байна.
Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.
Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50 000** (тавин мянга) төгрөгийг банкны меркантын системийг ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.
Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
1. Борлуулалтын хэмжээ:
**Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 онуудын борлуулалтын орлогын дундаж нь төсөвт өртгийн үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй байна.**
2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:
**Төсөвт өртгийн үнийн дүнгийн 30 хувиас доошгүй байх.**
3. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо:
**Сүүлийн 2 жилийн буюу 2015, 2016 онуудын аль нэг жилийн хугацаанд төсөвт өртөгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байна.**
4. Уг ажлыг гүйцэтгэхэд тусгай зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай эсэх: **“тийм”**
3.7.4.1 ЗЗА-1 Бүх төрлийн замын засварын ажил эсвэл
2.8.6. Хатуу болон хайрган хучилттай зам засварлах ажлыг гүйцэтгэх зөвшөөрөлтэй байх.
5. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:
**Сүүлийн 2 жил (2015, 2016 он) -ийн эцсийн санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлнэ.**

6. Тендерийн баталгааны үнийн дүн:
**“1,463,000” /нэг сая дөрвөн зуун жаран гурван мянга/ төгрөгийн тендерийн баталгаа ирүүлнэ.**

Цахим тендерт оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулна.

Тендерийг **2017 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 10:00 цагаас** өмнө цахим системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 10:30 цагт** Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын тендерийн нээлтийн 1012 тоот өрөөнд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.
Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Багатойруу-15, Самбуугийн гудамж, Нийслэлийн Засаг захиргааны IV байр, 10 давхарт Утас: 75757810,**

**Цахим хаяг: www.ub-procurement.mn, www.tender.gov.mn**

# ОНЦЛОХ ХУУДАС

# ЭРҮҮГИЙН ХУУЛЬ АЛДААТАЙ БОЛСОН, БОЛООГҮЙ

## Эсрэг тэсрэг байр суурь



### О.Баасанхүү: Үндэсний аюулгүй байдалд ноцтой аюул учирлаа

*/УИХ-ын гишүүн/*

-Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолд аюул учирлаа гэж үзэж байна. УИХ-аар баталсан Эрүүгийн хуулийн 19.1 заалтад "Монгол Улсын иргэн Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах хүчин чадалд хохирол учруулах зорилгоор дайны, дайн бүхий байдалд зэвсэгт халдлага мөргөлдөөн, түрэмгийллийн үед дайсны талд дэмжлэг үзүүлсэн, хамтран ажилласан бол 12-20 жил хүртэл эсвэл бүх насаар нь хорино" гэж заасан. Энэ нь эх орноосоо урвах гэдэг заалтыг соёлтойгоор байхгүй болгож байна. Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр зөвхөн дайны үед эх орноосоо урвах гэдэг заалт хамаарна. Бусад тохиолдолд хамаарахгүй болж буй нь ноцтой зүйл. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа өнөөдрийн Эрүүгийн хуулийн 79 дүгээр зүйлд "Монгол Улсын иргэн тус улсын тусгаар тогтнол үндэсний аюулгүй байдалд аюул учруулж болохуйц гадаад улсын тагнуулын албанд элссэн, төрийн нууцыг гадаад улсын тагнуулын албанд шилжүүлэн өгсөн, Монгол Улсын эсрэг дайсагнасан үйл ажиллагаа явуулдаг гадаад улсын байгууллагатай хамтран ажилласан, мөн дайн бүхий байдал зарласан үед дайны талд шилжин орсон бол 16-25 жил хугацаагаар хорих ял шийтгэнэ гэсэн байсан. Энэ хоёр заалтыг харьцуулан харвал шал өөр. Мөн "Монгол Улсын иргэн гадаад улсын тагнуулын албатай хамтран ажиллахаар тохиролцсон хамтран ажилласан гадаадын иргэн байгууллагад шилжүүлэн өгөх зорилгоор төрийн нууцад хамаатай мэдээ, баримт, эд зүйлийг хулгайлсан, хадгалсан, дамжуулсан бол 8-15 жилээр ял шийтгүүлнэ" гэдэг заалт шинээр батлагдсан нь маш ноцтой. Монгол Улсын төрийн нууцыг задруулсан бол найман жилийн л ял авах юм байна. Ийм л аюултай хуулийг ирэх долдугаар сарын 1-нээс мөрдөж эхлэх гэж байна. Хувийн сургууль төгссөн Х.Нямбаатар гээд хүүхэд ажлын хэсэг ахалсан нэртэйгээр Эрүүгийн хуульд янз бүрийн заалт оруулж байна. Ерөнхийлөгчийн сонгууль гээд хэрүүл хийж байх хооронд чинь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал алдагдаж байгаа юм биш үү, үүнийг эсэргүүцсэн хүнийг хэн ч биш болгодог, ганцаардуулах гэсэн технологи руу оруулж ирж байна. Энэ тухай би Тагнуулын ерөнхий газрын даргатай уулзаж, хэлсэн. Үе, үеийн Тагнуулын газрын дарга байсан хүмүүсийг дуудаж уулзаж, долдугаар сарын 1-ээс хууль хэрэгжихээс урьтаж, Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулна.

## Сэтгүүлчийн дүгнэлт

### Туршлагагүй "бацаан"-ууд төрийн хуулийн самарч гүйцлээ

Б.ТОГТОХ

УИХ-д Х.Нямбаатар гэдэг ганцхан гишүүн байдаг бололтой. Өөрөөр хэлбэл, хууль шүүхийн салбарын талаар түүнээс илүү мэдлэгтэй улстөрч энэ парламентад байдаггүй аж. Уул нь парламентад сууж буй УИХ-ын гишүүдийн талаас илүү хувь нь хуульч, үлдсэн хэсэг нь эдийн засагч мэргэжилтэй. Бүр хууль шүүхийн байгууллагад өмгөөлөгчөөр, хуульчаар, сайдаар ажиллаж байсан хүмүүс олон байгаа. Хуульзүйн сайдаар ажиллаж байсан, төрийн бүх хуулийг цээжээр мэдэх шахуу туршлагажсан Ц.Нямдорж гишүүнийг нэрлэж болж байна. Насаараа төр түшилцэж, хууль боловсруулах, батлах бүх үйл явцыг "ба, бэ"-гүй судалчихсан Д.Лүндээжанцан, Хуульзүйн сайдаар өдгөө ажиллаж буй С.Бямбацогт, Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнэ, УИХ-ын гишүүн Г.Занданшатар гэх мэтээр хуульч гишүүдийн жагсаалт хөвөрч гарна. Гэтэл сүүлийн үед УИХ-аар хэлэлцэж буй бүх хуулийн төслийн ажлын хэсгийг Х.Нямбаатар гишүүн ахлах болжээ. Х.Нямбаатарт хувийн сургуульд багшилж байснаас өөр туршлага байхгүй. Гэтэл хүний эрхийн асуудлыг тусгасан, хууль шүүхийн байгууллагын анхаарал татсан хуулийг боловсруулж, өргөн барьж хэлэлцүүлж, бантан хутгаж байгаа нь шүүмжлэл дагуулах болов. Өмнөх парламентын үед хэрэгжиж байсан хуулийг нэг өдөр хэлэлцэж, боловсруулаад оруулж ирсэн тохиолдол ч гарлаа. Хууль тогтоомжийн тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлыг нэг өдрийн дотор өргөн барьж, Ц.Даваасүрэн гишүүнээр загнуулаад амжсан. Туршлагагүй атлаа төрийн хууль самарч байгааг нь эрхэм гишүүн хатуухан хэлсэн ч тоосон шинжгүй зүтгүүлсээр хэлэлцүүлж дөнгөсөн билээ. Үнэхээр туршлагатай бол залуу хэмээн голох шаардлага байхгүй. Гэвч эрхэм гишүүний хэлэлцүүлж буй Эрүүгийн, Зөрчлийн, Хууль тогтоомжийн тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, Зөрчил шалган шийдвэрлэх зэрэг хуулийн төслүүдэд дандаа маргаан дагуулсан зүйл заалт агуулсан, хүний эрхийг ноцтой зөрчсөн заалтууд тусгасан байгаа юм. Д.Пүрэвдорж гишүүний хэлсэнчлэн завхарсан хуулийн төслүүд учраас МАН-ын луухгарууд дараа нь баалуулахгүйн тулд хойш сууж, харин залуу, туршлагагүй гишүүд нь бамбай болоод давхиж явна. Тухайлбал, Х.Нямбаатар нарын бантан болгосон Зөрчлийн тухай хуулийг экс гишүүн Х.Тэмүүжин сайд байх үедээ боловсруулж, "шоронжсон" бодлогыг зөөллөж, хэрэг үүсгэж шоронд хорих шаардлагагүй зарим асуудлыг зөрчил гэж тооцож албадан ажил хийлгэх, гэрийн хорионд байлгах, мөнгөн торгууль ногдуулах гэх мэтээр зөөллөх бодлого баримтлах тухай тусгасан байсан. Гэвч МАН-ын үед энэ хууль орж ирэхдээ жинхэнэ утгаараа бантан болж хувирлаа. Хатуухан хэлэхэд, мөнгө босгох, ард түмнийг зөрчил гэсэн зүйл заалтаар дарамтлах хууль болж хувирчээ. Тийм зөрчил гаргавал тэдэн саяар торгох гэдэг зүйл заалтад л анхаарснаас биш "шоронжсон" бодлогыг арилгах, хүний эрхийг хангах тухай ширхэг ч заалт тусгаагүй байх юм. Х.Нямбаатар үүнийгээ зайлшгүй тохиолдолд баривчлахаас өөр аргагүй хэмээн өмгөөлөөд сууж байна. Үндсэндээ зөрчлийн хууль бага хэмжээний "Эрүүгийн хууль" болсон нь худлаа биш. Нохойд барьдаг мод гэдэг шиг парламентын гишүүнээр сонгогдоод дөнгөж нэгхэн жил болж буй залуу гишүүдэд хуулийг даатгаж орхисноор энэ мэт хуулиуд завхарч, эргээд засах тухай, нэмэлт өөрчлөлт оруулна хэмээн маргаж сууна. Нөгөөдүүл нь ч үнэхээр дүрдээ итгэчихсэн. Хуулийн төслийн зорилгыг алдагдуулж, жинхэнэ утгаар нь самарчихснаа гавьяа байгуулчихсан аятай өмөөрөөд сууж байх юм. Х.Нямбаатар гэх залуу улстөрчийн нэр хүнд ч авах юмгүй боллоо. Улстөрчдийн гар хөлд гүйж явдаг "бууны нохой" аятай л болохгүй хуулиар оролдож баахан загнуулж байгаа нь худлаа биш. Эрүүгийн хууль ч эндээс хол зөрсөнгүй. Алдаа дутагдлыг нь ил хэлсэн нь О.Баасанхүү болохоос биш төрийн хуулийг өмнөхөөс дээрдүүлж чадсангүй. Төрийн өндөр албан тушаалтанд тал зассан, 10 сая төгрөгийн хохирол учруулаагүй бол барьж хорихгүй ээ хэмээн бантан хутгасан зүйл заалт оруулсан атлаа ядарсан иргэнээ 300 мянган төгрөг хумсалсан хэмээн дарамталж шоронд хийхээр тэд улайрч байгаа нь худлаа биш. Нөгөөтэйгүүр, энх цагт эх орноосоо урвахыг хуульд тусгаагүй гэх О.Баасанхүү гишүүний яриад буй асуудал ч үнэний ортой. Үнэхээр өмнөх хуульд энэ мэт алдаа байсан бол шинэчлэхдээ залруурах нь яагаа вэ. 2015 оны хуульд тусгачихсан юм аа, бидний буруу биш хэмээн хайцаалсаар суух хэрэг үү. Хуулийг засч, шинэчилнэ гэдэг өмнөхөөс сайжруулна гэсэн үг. Гэтэл О.Баасанхүү өмнөх хуулиар биднийг шантаажиллаа, тэр үедээ ярихгүй яагаа вэ гэсэн "гэнэн" хариулт өгөөд сууж боломгүй байлтай. Өмнөх алдааг засах гэж өөрчлөлт оруулаагүй бол өөр ямар асуудлыг шинэчлэх гэж яаран сандран хэлэлцэж байгаа нь хардлага төрүүлж буй юм. Х.Нямбаатар нарын хэлэлцүүлж буй эдгээр хуулиуд эхнээсээ л алдаа дутагдалтай батлагдаж байна. Тун удахгүй эдгээр хуулиудыг шинэчлэхээр өргөн мэдүүлнэ гэдэгт мөрийцсөн ч бэлэн байна.



### Б.Энхбаяр: Эрүүгийн хуулиас эх орноосоо урвасан зүйл заалтыг хасаагүй

*/Хуульзүй дотоод хэргийн дэд сайд/*

-Эрүүгийн хууль материаллаг хууль. Ямар үйлдлийг гэмт хэрэгт тооцох вэ, тэрэнд ямар шийтгэл ногдуулах вэ гэдгийг л зохицуулдаг. Монголын төрөөс гэмт хэрэгтэй тэмцэх бодлогоо Эрүүгийн хуулиар дамжуулан тодорхойлж байгаа. Шинээр батлагдсан Эрүүгийн хууль хоёр гол онцлогтой. Нэгдүгээрт, авлига албан тушаал, эдийн засгийн гэмт хэрэгт ногдуулах ял шийтгэлийн бодлогыг эрс чангалсан. Энэ төрлийн гэмт хэрэгтэй хайр найргүй тэмцэхээ Засгийн газар, УИХ хэлж өглөө. Одоо байгаа хуулиар албан тушаалаа урвуулсан, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар ашигласан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлснээс дээш хохирол шаарддаг. Өөрөөр хэлбэл, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 240 мянга гэж тооцохоор 12 сая төгрөгөөс дээш хохиролтой гэмт үйлдлийг гэмт хэрэгт тооцдог байсан. Одоо бол татвар төлөгч болон улсын мөнгөнөөс нэг төгрөг хулгайлсан бол гэмт хэрэгт тооцон ял шийтгэхээр болж байгаа. Мөн шинэ хуулиар хохирлыг заавал барагдуулна. Хоригдох юм чинь хохирлыг барагдуулахгүй байсан ч яадаг юм гэсэн байдлаар ханддагаас маш олон хүний хохирол төлөгддөггүй. Тэгвэл энэ асуудлыг цэгцэлж, хэрвээ хохирлоо төлсөн бол ялыг нь хөнгөлдөг байх заалт оруулсан. О.Баасанхүү гишүүн эх орноосоо урвах зүйл заалтыг Эрүүгийн хуулиас хасчихсан байна гэж ярьсан. Тийм зүйл байхгүй. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн эх орноосоо урвах зүйл ангид дайны байдлын үед дайсны талд элссэн, хамтарч ажилласан, Монгол Улсад тагнуул хийсэн, Монгол Улсын иргэн гадаадын тусгай албанд элссэн, хамтарч ажилласан, улсын нууц задруулсан үйлдлийг бүгдийг нь нэг гэмт хэрэгт багтаан бичсэн байдаг. Өнгөрсөн парламент хууль батлахдаа үүнийг дөрвөн гэмт хэрэг болгосон байдаг. Нэгдүгээрт, эх орноосоо урвах, хоёрдугаарт, гадаад улсын тагнуулын байгууллага, иргэнтэй хамтарч ажиллах, гуравдугаарт тагнуул хийх, дөрөвдүгээрт, улсын нууц задруулах гэх дөрвөн гэмт хэрэг болгосон. Үүнийг шинэ хуульд огт хөндөөгүй. Гэтэл О.Баасанхүү гишүүн өмнөх парламентын үеийн асуудлыг одоо яриад байгаа юм. Энэ Засгийн газар, Их хуралтай ямар ч хамаагүй. Хоёрдугаарт, О.Баасанхүү гишүүн эх орноосоо урвах үйлдэлд зөвхөн дайны байдалд хамаарч байна. Энхийн цагт дайсны талд орохыг мөн оруул гэж яриад байгаа. Дайсан гэдэг ойлголт зөвхөн дайны үед яригддаг ойлголт. Энхийн цагт аль нэг улстай дайтаагүй үед аль нэг улсыг дайсан гэж зарлаж болохгүй. Эх орноосоо урвахыг гэмт хэрэгт тооцохоо больсон зүйл огт байхгүй. Үнэхээр тэгсэн бол хууль тогтоох байгууллага юу хийж суух билээ. Улсын нүд чих болсон тагнуулын байгууллага ч юу хийж суух билээ. Нийтийн дунд ташаа мэдээлэл түгээж байгаа учраас хэлэхгүй байх арга алга.

# ЦАГ ҮЕ

Аймгаас мэдээлж байна

ОРХОН АЙМАГ

## Ил задгай худалдаа эрхлэгчдийг цэгцэлж байна

Орхон аймгийн "Хүлэг" хүнсний захын орчимд явган хүний зам болон авто машины хөдөлгөөнд саад учруулж буй ил задгай худалдаа эрхлэгчдийг цэгцлэхээр болжээ. Ил задгай худалдаа эрхэлж байгаа иргэдийг "Худалдааны гудамж"-нд төвлөрүүлж, харин түрээс төлөх боломжгүй иргэдийг аймгийн томоохон худалдааны төвүүдэд түрээсгүйгээр ажиллуулахаар болсон байна. Дээрх зохицуулалтыг хийхдээ аль болох иргэдийг хохироохгүй байхаар тооцжээ. Тухайлбал, "Худалдааны гудамж"-ийг соёл амралтын хүрээлэн буюу ОХУ-ын Буриад улсын Улаан-Үүд хотын "Арабат"-ын гудамж шиг тохижуулж үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөсөн байна. Уг гудамж 2015 онд ашиглалтад орсон ч ил задгай худалдаа эрхлэгчдэд зориулсан нийтийн бие засах газаргүй, автомашины зогсоолгүй, цахилгааны утас татагдаагүй байсан юм. Үүнийг цэгцлэхээр "Эрдэнэт-Ус ДТС" ОНӨХК ажиллаж байна. Мөн Баян-Өндөр сум ил задгай худалдаа эрхлэгчдэд зориулж дөрвөн ширхэг зөөврийн павильон гаргах бөгөөд үүнийг иргэд худалдаж авах эсвэл түрээслэх боломжтой гэнэ. 3х6 харьцаатай павилоны өөрийн өртөг 4.5-5 сая төгрөг ажээ.

ӨМНӨГОВЬ АЙМАГ

## "Жаргалтай айл манайх" зөвлөгөөн боллоо

Өмнөговь аймаг олон улсын гэр бүлийн өдрийн тохиолдуулан 20600 гаруй өрхийг хамруулан "Жаргалтай айл манайх" зөвлөгөөнийг өчигдөр зохион байгууллаа. Тус үйл ажиллагааг анх удаагаа Өмнөговь аймаг зохион байгуулж байгаа гэдгээрээ онцлог аж. Зөвлөлгөөнд Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, СГЗ, Ардын уран зохиолч, яруу найрагч Бавуугийн Лхагвасүрэн урилгаар оролцож "Монгол ухаан" сэдвээр лекц уншсан байна. Мөн "Гэр бүлийн өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд "Миний гэр бүл" гэрэл зургийн уралдаан, аавдаа бичих захидал, шилдэг гэр бүлийг шалгаруулсан байна. Дээрх зөвлөгөөний үеэр аз жаргалтай гэр бүлийн нууц, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, хүүхэд хүмүүжүүлэх зэрэг арга, гэр бүлийн санхүүгийн хуримтлал бий болгох нь зэрэг чухал сэдвүүдээр мөн хэлэлцүүлэг өрнүүлжээ.

МЭДЭЭЛЭЛ

## Горхи-Тэрэлжийн хамгаалалтын захиргааныхан мод тарив

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааныхан мод тарих үндэсний өдрөөр мод тарилаа. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас жил бүр уламжлал болгон зохион байгуулж заншсан "Бүх нийтээрээ мод тарих" өдрийг тохиолдуулан тус яамны харьяа байгууллага болох Горхи-Тэрэлжийн цогцолборын захиргаанаас иргэд, аж ахуйн нэгжүүдтэй хамтран долоон байршилд мод тарьсан байна. Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга Д.Батмөнх хэлэхдээ "Тэрэлж бол манай улсын байгалийн өвөрмөц тогтоц, биологийн төрөл зүйл, экосистемийн онцлог төрхтэй нийслэл Улаанбаатар хотын ундны цэвэр усны нөөцийн эх сав газар. Монгол орны экологийн тэнцлийг хангахад онцгой ач холбогдол бүхий газарт жилээс жилд эко системийг хөгжүүлэхэдаялагчдын учруулсан хогийг цэвэрлэж, мод тарих нь маш чухал юм. Өнөөдрийн байдлаар манай захиргааныхан, нэлээн олон аж ахуй нэгжүүдтэй хамтран нийт долоон байршилд мод тарьж байна" гэв. Мод тарьж буй аж ахуйн нэгжүүдийн нэг болох "Golden gem фитнесс" клубынхэн Туул голын "Дугуй бургас" гэдэг өнгөрсөн бямба гаригт 1200 мод тарьжээ. Тэднийхэн долоон хоногийн турш Туул голын хур хогийг цэвэрлэж, олон тонн хог ачсан талаараа ярьж байв.




АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# Т.Бадрал: ТӨРИЙН ӨМНӨӨС ҮҮРЭГ НИЙГМИЙН БАТАЛГАА

Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ

*Монгол Улсын нэр хүндийг дэлхий дахинд өргөсөн томхон үйл явдал Азийн цээжинд орших Монгол Улсад амжилттай зохион байгуулагдсан юм. Тэр нь "Говийн чоно-2017" олон улсын дадлага сургуулилтын арга хэмжээ. Энэхүү арга хэмжээг Монгол Улсын Засгийн газар, ОБЕГ амжилттай зохион байгуулсныг АНУ-ын Номхон далайн цэргийн командлал өндрөөр үнэлснийг уншигч таны сонорт дуулгахад таатай байна. Тэгвэд дэлхийн сонорт хүрсэн энэхүү томоохон арга хэмжээг зохион байгуулсан ОБЕГ-ын дарга Т.Бадралтай уулзаж ярилцлаа.*

**-Монгол Улс "Говийн чоно-2017" олон улсын дадлага сургуулилтын арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. ОБЕГ-ын даргын хувьд сэтгэл хангалуун байна уу?**

-"Говийн Чоно-2017" олон улсын дадлага сургуулилтыг эх орондоо зохион байгуулах хүсэлтээ Засгийн газар болон ОБЕГ-аас 2008 онд АНУ-ын Элчин сайдын яамаар дамжуулан АНУ-ын Номхон далайн цэргийн командлалд тавьсан. Тухайн үед манай улс гамшгаас хамгаалах нөхцөл байдал, гамшиг тохиолдсон үед авах хариу арга хэмжээ тааруухан байсныг нуугаад яах вэ. ОБЕГ байгуулагдаад удаагүй, дөрөвхөн жил болж байлаа шүү дээ. Аливаа гамшиг ослын үед хариу арга хэмжээг яаралтай авах нь нэг улс үндэстний гэхээс илүү бүс нутгийн хамтын ажиллагааны асуудал болохыг сүүлийн арван хэдэн жилд гарсан том, том гамшгууд харуулсан. Жишээ нь Япон бол эдийн засгийн чадамжтай том улс. Гэтэл 2011 оны гуравдугаар сарын 11-нд болсон гурвалсан гамшиг буюу цунами, газар хөдлөлт, цөмийн аюулгүй байдал алдагдахад хүчин мөхөсдөж, бүс нутгийн улс орнуудаас тусламж хүссэн. Монгол Улс авран хамгаалах, эрэн хайх багаа илгээж байлаа. Хэдийгээр бидний илгээсэн баг туршлага дутмаг ч ядрах цагт нөхрийн чанар танигдана гэдгээр чадлынхаа хэрээр үүргээ амжилттай биелүүлээд ирсэн. Мөн хоёр жилийн өмнө Непальд хүчтэй газар хөдлөлт болоход Засгийн газарт нь хариу арга хэмжээ авах боломж байгаагүй. Өөрөөр хэлбэл, чадал нь хүрээгүй. Сычуаны газар хөдлөлт ч ялгаагүй. Энэ бүхэн юу хэлж байна вэ гэхээр, гамшгийн хор хөнөөл, хохирол тухайн орны хүчин чадлаас давсан тохиолдолд бүс нутгийн хамтын ажиллагааны хүрээнд шийдэхээс өөр гарц байдаггүй гэдгийг бид хаа хаанаа ойлгох ёстой. "Говын чоно-2017 " олон улсын дадлага сургуулилтын арга хэмжээг ОБЕГ 2008 оноос зохион байгуулсаар ирсэн. Энэ жилийнх зургаа дахь нь. ОБЕГ-ын бие бүрэлдэхүүн, Өмнөговь аймаг дахь манай ОБГ энэхүү арга хэмжээг орон нутагтаа өндөр төвшинд амжилттай зохион байгуулсныг энд онцлон тэмдэглэхийг хүсч байна.

**-Номхон далайн цэргийн командлал олон улсын дадлага сургуулилтын арга хэмжээг Монгол Улсад тэр дундаа орон нутагт зохион байгуулах эрхийг өгөхдөө ямар нэг шалгуурыг тавьсан уу?**

-АНУ- Монгол Улсын хамтын ажиллагааны хүрээнд шийдэгдсэн асуудал. Өмнө нь хийгдэж байсан дадлага сургуулилт зөвхөн хоёр орных байсан бол өдгөө цар хүрээ нь өргөжин олон улсын хэмжээний дадлага сургуулилт руу шилжсэн. Батлан хамгаалах салбар Зэвсэгт хүчний хэмжээнд зохион байгууллагддаг "Хааны эрэлд" олон улсын дадлага сургуулилтыг "Говийн чоно"-ыг адилтгаж болно. Нэг төвшиний хоёр өөр салбарын арга хэмжээ гэж ойлгох хэрэгтэй. Энэ жил Ази Номхон далайн орнуудаас Тайланд, Пакистан, Энэтхэг зэрэг байгалийн гамшиг байсхийгээд болдог орны ОБЕГ-аас "Говийн чоно" олон улсын дадлага сургуулилтын арга хэмжээнд ажиглагчийн байр сууриас бус багийн бүрэлдэхүүнтэй ирж оролцох хүсэлтээ ирүүлж буйгаас үзэхэд бүсийн нутгийн улс орнууд энэхүү арга хэмжээнд өндөр ач холбогдол өгч байгаагийн илэрхийлэл буй за. Хамгин гол нь бүсийн улс орнуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх цаашлаад өөрийн орны бие бүрэлдэхүүний чадавхийг сайжруулах нь "Говийн чоно"-ын гол зорилго чиглэл байсан. Нөгөөтэйгүүр, шинээр батлагдсан Гамшгаас хамгаалах тухай хуульд гамшгийн эрсдлийг бууруулах болон гамшиг гарсан тохиолдолд авах хариу арга хэмжээг дээшлүүлэх тухай асуудал онцгой байр суурьтайгаар тусгагдсан. Учирч болзошгүй гамшиг ослын хэмжээ тухайн аймаг, орон нутаг цаашлаад тухайн улс үндэстний Засгийн газрын хүрээнээс давсан тохиолдолд гадны улс орнуудтай хэрхэн хамтран ажиллах вэ гэдгийг энэхүү дадлага сургуулилтаас мэдэж авах юм. Дэлхий дахинд тохиолдсон гамшиг ослыг даван туулах тусам засч залруулах алдаа эндэгдэл гарч ирсээр байна. Монгол Улсын хэмжээнд газар хөдлөлтийн чичиргээний давтамж ойртож, хот суурин газарт гэлтгүй хөдөө, орон нутагт мэдрэгдэж буй.

СУДЛААЧИЙН ҮГ

# НЯГТЛАН БОДОГЧИЙН МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙН ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХ НЬ

Хүмүүнлэг энэрэнгүй иргэний ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжин орсоноор өмнөх нийгмийн улбаа, түүний үнэт зүйлс өөрчлөгдөж шинэ сэтгэлгээ, шинэ чиг хандлага бий болж эхэлсэн билээ. Тэдгээр их өөрчлөлтийн нэгээхэн хэсэг нь мэргэжлийн ёс зүйн тухай ойлголт бий болсон явдал юм. Өмнөх нийгмийн тогтолцоонд захиран тушаах хэлбэр илүү давамгай байдалтай оршиж байсан бол 1990-ээд оноос нийгэмдээ, иргэндээ үйлчилдэг, мэргэжлийн ёс зүйг дээдэлдэг үйлчилгээ илүү давамгайлах хандлага бий болоод байна. Тэр дундаа нягтлан бодогчийн мэргэжил гэдэг бол ёс зүйг дээдэлсэн, мөн хариуцлага өндөр байхыг шаарддаг чухал мэргэжил юм. Мэргэжлийн ёс зүй хэмээх ойлголт XX зууны эхэн үеэс өрнө дахины орнуудад бий болсон бөгөөд мөн зууны сүүл хагас гэхэд олонхи улс орнуудад ихээр хөндөгдөх болжээ. Мэргэжлийн ёс зүйг эрхэмлэн ажиллаагүйгээс мэргэжлийн нэр хүндийг санаатайгаар болон санамсаргүйгээр унагах байдал нийгэмд ихээхэн газар авч байгаа талаар дэлхийн улс орнууд сүүлийн жилүүдэд хүчтэй хөндөн хэлэлцэж байна. Манай улсад энэ байдал мөн даамжирсан мэргэжлийн нэр хүнд унагаасан явдал ихээхэн гарч байгаа нь нягтлан бодогч мэргэжил, нягтлан бодогч нар нийгэмд сөргөөр ойлгогдох боллоо. Мэргэжлийн ёс зүйн тодорхой ойлголттой байж тухайн мэргэжлийн ажлыг алдаа зөрчилгүй хийж гүйцэтгэх нь тэр мэргэжилтний заавал биелүүлэх үүрэг билээ. Гринвүд, Бернс, Хага нарын болон бусад эрдэмтдийн ажиглалтаар мэргэжил бүхэн гишүүдийнхээ үйл ажлын горимыг тодорхойлсон ёс зүйн дүрэмтэйг тогтоожээ. Үе үеийн хүмүүс, түүний дотор нягтлан бодогч бүхэн үйл ажиллагааныхаа явцад ёс зүйн сонголт хийх асуудалтай тулгарсаар байдаг. Хөдөлмөрийн процесст тааралдах олон олон нөхцөл байдал нь хүмүүнийг ёс суртахууны хувьд буруу алхам хийхэд өдсөөр байдаг аж. Ийм учраас нягтлан бодогч нь нягтлан бодогч мэргэжлээ сайн эзэмшихүйд тавигдах үндсэн шаардлагын нэг нь ёс зүйн хувьд зөв үйлдэл хийдэг байх явдал юм.




Тухайлсан мэргэжилд хамаарал бүхий бүх хүмүүс нийгэмд ач тустай ажил үйлчилгээ хэрэгжүүлэлтийг эрхэмлэн хувийн ашиг сонирхлоосоо дээгүүр тавьж, өөрөөр хэлбэл альтруизм (мэдлэг чадвараа бусдын сайн сайхны төлөө өөрийнхийгөө умартан харамгүй зориулах)-ыг урьтал болгон ажиллах ёстой. Гэтэл нягтлангийн мэргэжил сүүлийн жилүүдэд туйлын зорилтоосоо ухарч, нягтлангууд заримдаа хувийн ашиг сонирхлоо эд материалын бодит үнэ цэнээр хэмжин тогтоодог болжээ. Нягтлан бодогч нар хийж гүйцэтгэсэн ажлынхаа чанар чансаа эргэлзээгүй гэдэгтээ итгэлтэй, хэнээс ч, юунаас ч хамааралгүй тусгаар бөгөөд мэргэжлийн ур чадвар, ёс зүйг дээдлэн ажилласнаар мэргэжлийнхээ нэр төрийг хамгаалж нийгмийн итгэлийг мэргэжилдээ хандуулж чадваас ба энэ нь хамгийн гол эрхэмлэх зүйл билээ. Иймээс нягтлан бодогч мэргэжлийн ёс зүйн асуудлаар зарим зүйлийг тодорхойлох зорилготойгоор Төрийн болон бизнесийн байгууллагад ажилладаг нягтлан бодогчдын төлөөллүүдээс асуулга судалгааг авсан. Санхүүгийн тайланг хуурмаг болгохыг шаардсан удирдлагын шахалтанд ихэвчлэн бизнесийн байгууллагад ажилладаг нягтлан бодогчид орж байсан бөгөөд төрийн байгууллагын нягтлан бодогчид харьцангуй бага өртдөг болох нь харагдаж байсан. Энэ нь төрийн байгууллагуудын хувьд хуваарилагдсан төсвийн зарцуулалтыг нягтлан бодох бүртгэлийн нээлттэй системээр буюу шилэн дансны аргад шилжсэнтэй холбоотой гэж үзэж байна.

Төрийн болон бизнесийн байгууллагуудын нягтлан бодогчдын ажлын арга барил, удирдлагаас ирэх дарамт шахалт болон ажлын ачаалал нэлээдгүй ялгаатай байдаг ба энэ нь нягтлан бодогчдын мэргэжлийн ёс зүйн асуудалд нөлөөлж байдаг учир бизнесийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд НББ болон аудитын стандартын хэрэгжилтийг хангуулах үүднээс системтэй, үр дүнтэй хяналтын тогтолцоог сайжруулах шаардлагатай гэж үзэж байна.

СЭЗИС-ийн магистрант Б. МӨНГӨНТУЯА

ЦАГ ҮЕ

# ХҮЛЭЭДЭГ ХҮМҮҮСИЙН ӨНДӨР БАЙХ ЁСТОЙ

Өнгөрсөн оны арваннэгдүгээр сард Өмнөговь аймгийн Цогтцэций суманд болсон газар хөдлөлтийн чичиргээ ОБЕГ-ын нийт бие бүрэлдэхүүнийг төдийгүй орон нутаг өөрөө бэлэн байхыг сануулж буй том анхааруулга гэдгийг ойлгох ёстой.

**-"Говийн чоно-2018 оныг зохион байгуулах эрхийг Монгол Улсад дахин олгох аваас оролцогч орон хийгээд бие бүрэлдэхүүн нэмэгдвэл түүнийг хүлээн авах хүчин чадал бидэнд байна уу. Миний хэлэх гэсэн санаа бол Зэвсэгт хүчин шиг сургалтын баазтай болох нь ялангуяа таны ажил, таны зорилго бус уу?**

-Тантай санал нэг байна. Миний, бидний маргаашийн зорилгыг та онож хэллээ. Монгол Улсад төдийгүй бүс нутгийн хэмжээнд гамшиг гарсан тохиолдолд манайх өөрийн багийг илгээх чадавхтай байх ёстой. Олон улсад үүрэг гүйцэтгэх багийг маш богино хугацаанд зохион байгуулах хуультай. НҮБ-ын Олон улсын эрэн хайх, аврах бүлгийн ангилал бүхий баг 65 хүний бүрэлдэхүүнтэй байдаг. Өнөөдрийн байдлаар тэрхүү багт багтах эмч, аврагч, нохой хөтлөгч нарыг бэлтгэх сургалтын бүртгэл манай улсад эхэлсэн. Тэднээс сонгон шалгаруулж, олон улсад илгээх багийг бүрдүүлнэ. Тодруулбал, АНУ-ын Номхон далайн командлалаас тавьж буй шаардлагыг хангасан тохиолдолд Монгол Улс бүс нутагтаа үйлчлэх эрх бүхий багтай болох юм. Тийм орон цөөн шүү дээ. Нөгөө талдаа Монгол Улсад том хэмжээний гамшиг гарсан тохиолдолд гаднаас ирэх олон улсын баг бие бүрэлдэхүүнийг хүлээж авах асуудал үүснэ. Үнэнийг хэлэхэд, бие бүрэлдэхүүний чадавхиас илүүтэй тэдний техник тоног төхөөрөмжийг хилээр нэвтрүүлэх, гаалийн татвараас чөлөөлөх асуудал бидний сэтгэлийг зовоодог. Сая батлагдсан Гамшгаас хамгаалах тухай хуульд гаднаас орж ирж байгаа хүмүүнлэгийн тусламж гэсэн бүхэл бүтэн бүлэг бий. Хуулийн хүрээнд гадны улс орноос хүмүүнлэгийн тусламж авах, эрэн хайх багийг Монголд нэвтрүүлэх, ажиллуулах, буцаах журмыг нэн даруй хуульд нэмэлт, өөрчлөлтөөр оруулах ёстой. Мөн хуулийн үйлчлэл ямар хүрээг хамрах вэ гэхээр Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагаас гадна хүмүүнлэг, гамшгийн үед авах хариу арга хэмжээнд оролцож байгаа олон улсын болоод төрийн бус байгууллагууд багтах ёстой. Олон улсын Улаан загалмайн нийгэмлэг болон олон улсын техникийн экспертүүд Монгол Улсад дэмжлэг үзүүлэхээ илэрхийлсэн байгаа. Монгол Улс энэ бүхнийг багтаасан журамтай болсон тохиолдолд гадны эрэн хайх, аврах багуудыг хүлээж авах эрх зүйн орчин бүрдэх юм. Бидний тооцоолж буйгаар 2018 оы нэгдүгээр сар гэхэд журам батлагдах байх.

**-ОБЕГ АСЕМ-тай дүйцэхүйц арга хэмжээг Улаанбаатар хотноо зохион байгуулахаар болсон. Бэлтгэл ажлын явц ямар байгааг сонирхвол?**

-Гамшгийн эрсдлийг бууруулах чиглэлээр дэлхийн 86 улс хүлээн зөвшөөрч баталсан дагаж мөрдөх Тунхаг бичиг гэж байдаг юм. Үүнийг бүс нутгийн хэмжээн мөрдөж, хамтран ажиллах өөрсдийн төлөвлөгөөг улс үндэстэн бүр өөр өөрийн төлөвлөгөөний дагуу журмаа баталдаг. Эл хүрээнд Монгол Улсад гамшгийн эрсдлийг бууруулах түүнчлэн бүс нутгийн хэмжээний гамшгийг бууруулах Сайд нарын бага хурлыг Монгол Улс 2018 онд зохион байгуулах эрхийг авсан. Монгол Улсын Засгийн газар, Ерөнхий сайдын захирамжаар ажлын хэсэг байгуулагдсан. Монгол Улсын Шадар сайд ажлын хэсгийг ахалж буй. Ажлын хэсэг хоёр ч удаа хуралдсан. Түүнчлэн, Монгол Улс Сайд нарын бага хурлын зорилго зорилтыг тодорхойлсон. Сүүлийн жилүүдэд хот суурин газарт гамшиг болох эрсдэл өндөр болж байна. Тиймээс гамшгийг даван туулах чадавхийг гол зорилтоо болгоё. Нөгөөх нь гамшгийн эрсдлийг бууруулахад зарцуулагдах хөрөнгө оруулалтыг хэрхэн шийдэх талаар санал солилцох юм. Манайд 2018 онд хуралдах Сайд нарын бага хурлаар хэлэлцэх үндсэн асуудал нь энэ хоёр.

**-Санхүүжилт нь шийдэгдсэн үү?**

-Монгол Улсын Засгийн газар бэлтгэл ажилдаа хэдийнэ орсон. Төсөв санхүүтэй холбоотой асуудлыг шат шатандаа шийдэж байгаа. НҮБ-д гамшгийн эрсдлийг бууруулах олон улсын стратегийн төв гэж байдаг. Энэ төвтэй хамтран ажиллаж байгаа.

**-ОБЕГ-ын үйл ажиллагаа жилээс жилд өргөжин хөдөө, орон нутаг дахь анги нэгтгэлийн статус газар болсон байна лээ. Бие бүрэлдэхүүн өргөжихийн хэрээр хөрөнгө санхүүжилт нэмэгдэж таарна?**

-Байгууллагын статусыг нэмэгдүүлнэ гэдэг санаан зоргоор бүтэх ажил биш. Хөрөнгө санхүү, хүний нөөцийн асуудал хамгийн түрүүнд тулгардаг. Өмнө нь хөдөө, орон нутагт Онцгой байдлын хэлтэс байсан бол эдүгээ газар болж өргөжсөн. Тэр хэрээр ангиудын зэрэглэл нэг шатаар ахисан. Дээр нь авран хамгаалах, эрэн хайх анги, салбаргүй сум, суурин газарт шинээр албыг байгуулсан. Түүнчлэн салбарын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байсан анги, бүлгүүдийг салбар болгох зэргээр зэрэглэлийг нь ахиуллаа. Гэхдээ бүх зүйл бидний санаснаар болохгүй юм. Улс орны эдийн засгийн байдал ч нөлөөлж байна. Ямартай ч 2020 гэхэд техник, тоног төхөөрөмж, парк шинэчлэлийн асуудлаа шийдэх төлөвлөгөөтэйгөөр ажиллаж буй. Албан хаагчдын орон тооны асуудал хүндхэн байна. Өнгөрсөн 2015,2016 онд найман анги шинээр байгуулагдсан.Тэр хэрээр орон тоо нэмэгдсэн. Мөн энэ онд гурав, 2018 онд дөрвөн ангийг шинээр нэмж байгуулна. Орон тооны хувьд шинээр байгуулагдсан ангиудын хэмжээнд яригдаж байгаа болохоос хуучин анги нэгтгэлийн хүчин чадлыг нэмэх боломжгүй. Шинэ зохион байгуулалтын хүрээнд 2018 оны төгсгөл гэхэд хүн хүчний асуудал бүрэн шийдэгдэх учиртай. Зэрэглэл нь ахисан ангиудын тухайд хүн нэмэхээс илүү сургалтад хамруулах асуудлыг түлхүү ярина. Ер нь манай байгууллага онцгой байдлын албанд алба хаах хүсэлтэй иргэдэд тавих шаардлагаа өндөр болгосон. Сонирхол бүхий залуучуудын тоо ч нэмэгдсэн.

**-Онцгой байдлын албанд ажиллах сонирхолтой залуучуудын тоо жилээс жилд нэмэгдэж байгаа нь Ерөнхий газрын зүгээс ажилчдынхаа нийгмийн асуудлыг маш сайн шийдэж байгаа учраас нийгэм сайнаар хүлээн авч байгаа хэрэг?**

-Ерөнхий газрын баримталж буй бодлого гэвэл ярих бус бодит ажил болгохыг чухалчилсаар ирсэн. Өдгөө алба хааж буй залуучуудаа насны хувьд авч үзэхэд 25-30 насныхан зонхилж буй. Залуу гэр бүлд бүх зүйл хэрэг болдог. Тиймээс тэдэнд ар гэртээ санаа зовохгүйгээр үүрэг гүйцэтгэх тийм нөхцлийг бүрдүүлэх нь бидний үүрэг. Манай албан хаагчид маш онцгой, хүнд нөхцөлд үүрэг гүйцэтгэдэг. Хувь хүнээс сэтгэлийн тэнхээ, мэдлэг боловсрол, хурд хүч, авхаалж самбаа шаарддаг алба. Хүний амь настай холбоотой асуудал минут секунтээр хэмжигддэг. Зарим тохиолдолд өөрөө ч амь насаа алдаж болно. Төрийн өмнөөс үүрэг хүлээдэг хүмүүсийн нийгмийн баталгаа өндөр байх ёстой юм. Албан хаагчдынхаа нийгмийн асуудлыг шийдэх гарцыг хуулийн төсөлд тусгаж өгсөн. Удахгүй шийдэгдэх байх. Хууль, эрх зүйн бичиг баримт нь бүрдчихвэл зохион байгуулах нь бидний хувьд асуудалд хойш суух, түүртэх явдалгүй. Ер нь аливаа байгууллага удирдаж буй хүнээсээ шалтгаалдаг. Би газар, хэлтэс, албадынхаа дарга нарт нэг л шаардлагыг тавьдаг. Энэ нь юу гэхээр хамгийн гол нь асуудлын цаана хүний амьдрал явж байдаг учраас нийгмийн баталгааг хангах чиглэлээр тодорхой ажлуудыг хийхийг шаарддаг. Төрд зүтгэж байгаагийн хувьд хамгийн өндөр цалин, урамшуулал авах ёстой. Мөн нийгмийн баталгаа нь бүрэн хангагдсан байх ёстой гэж боддог доо.

PHOTO NEWS





*Нийслэлийн Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэр Гурвалжингийн гүүрний зүүн урд талд Хөөсөнцөр сэндвич хавтангийн "NOTS" үйлдвэрт гал гарч Нийслэлийн Онцгой байдлын газарт 12:02 цагт түймрийн дуудлага иржээ. НОБГ-аас гал унтраах гурван анги ажилласан бөгөөд нөхцөл байдал хүндэрч нэмэлт хүч очин ажиллалаа. Түймэр гарсан шалтгаан одоогоор тодорхойгүй байгаа юм. Галыг 13:00 цагт бүрэн унтраасан бөгөөд гэмтэж бэртсэн хүн байхгүй хэмээн албаныхан хэллээ.*

*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*


# ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдөр
**Тендер шалгаруулалтын нэр:** Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Зоригийн гудамжийг Чагдаржавын гудамжтай холбох авто замын ажил
**Тендер шалгаруулалтын дугаар:** НХААГ-17/0107

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар эрх бүхий тендерт оролцогчдоос: Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Зоригийн гудамжийг Чагдаржавын гудамжтай холбох авто замын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50 000 (тавин мянга) төгрөгийг банкны меркантын системийг ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. **Үүнд:**

**1. Борлуулалтын хэмжээ:**
Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 онуудын борлуулалтын орлогын дундаж нь төсөвт өртгийн үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй байна.

**2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:**
Төсөвт өртгийн үнийн дүнгийн 30 хувиас доошгүй байх.

**3. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо:**
Сүүлийн 2 жилийн буюу 2015, 2016 онуудын аль нэг жилийн хугацаанд төсөвт өртөгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байна.

**4. Уг ажлыг гүйцэтгэхэд тусгай зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай эсэх:** "тийм"
3.7.4.1 ЗЗА-1 Бүх төрлийн замын засварын ажил эсвэл
2.8.6. Хатуу болон хайрган хучилттай зам засварлах ажлыг гүйцэтгэх зөвшөөрөлтэй байх.

**5. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:**
Сүүлийн 2 жил (2015, 2016 он) -ийн эцсийн санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлнэ.

**6.Тендерийн баталгааны үнийн дүн:**
"2,070,000 төгрөг" /хоёр сая далан мянга/ төгрөгийн тендерийн баталгаа ирүүлнэ.

Цахим тендерт оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулна.

Тендерийг 2017 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 09:30 цагаас өмнө цахим системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 10:00 цагт Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын тендерийн нээлтийн 1012 тоот өрөөнд нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.**
**Дотоодын давуу эрх тооцно.**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Багатойруу-15, Самбуугийн гудамж, Нийслэлийн Засаг захиргааны IV байр, 10 давхарт Утас: 75757810,**
**Цахим хаяг: www.ub-procurement.mn, www.tender.gov.mn**



# ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдөр
**Тендер шалгаруулалтын нэр:** Сонгинхайрхан дүүрэг, 29 дүгээр хороо, 1 дүгээр хорооллын арын замаас Үйлдвэрчний эвлэлийн гудамж руу Москва хорооллын араар холбох шинэ замын ажил
**Тендер шалгаруулалтын дугаар:** НХААГ-17/0103

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар эрх бүхий тендерт оролцогчдоос : Сонгинохайрхан дүүрэг, 29 дүгээр хороо, 1 дүгээр хорооллын арын замаас Үйлдвэрчний эвлэлийн гудамж руу Москва хорооллын араар холбох шинэ замын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50 000 (тавин мянга) төгрөгийг банкны меркантын системийг ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. **Үүнд:**

**1. Борлуулалтын хэмжээ:**
Сүүлийн 2 жил буюу 2015, 2016 онуудын борлуулалтын орлогын дундаж нь төсөвт өртгийн үнийн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй байна.

**2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:**
Төсөвт өртгийн үнийн дүнгийн 30 хувиас доошгүй байх.

**3. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо:**
Сүүлийн 2 жилийн буюу 2015, 2016 онуудын аль нэг жилийн хугацаанд төсөвт өртөгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байна.

**4. Уг ажлыг гүйцэтгэхэд тусгай зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай эсэх:** "тийм"

**Зам Тээврийн Хөгжлийн яамны:**
3.7.4.1 ЗЗА-1 Бүх төрлийн замын засварын ажил эсвэл
2.8.6. Хатуу болон хайрган хучилттай зам засварлах ажлыг гүйцэтгэх зөвшөөрөлтэй байх.

**Эрчим хүчний яамны:**
03.2.1. Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт /0.4-10 кв/
эсвэл,

**Барилга, Хот байгуулалтын яамны:**
1.2.8. Цахилгаан эрчим хүч дамжуулах гол /магистраль/ шугам /35 кВ хүртэл/ угсралт

**5. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:**
Сүүлийн 2 жил (2015, 2016 он)-ийн эцсийн санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлнэ.

**6. Тендерийн баталгааны үнийн дүн:**
"11,928,000 төгрөг" /арван нэгэн сая есөн зуун хорин найман мянга/ төгрөгийн тендерийн баталгаа ирүүлнэ.

Цахим тендерт оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулна.

Тендерийг 2017 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 08:30 цагаас өмнө цахим системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 09:00 цагт Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын тендерийн нээлтийн 1012 тоот өрөөнд нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.**
**Дотоодын давуу эрх тооцно.**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Багатойруу-15, Самбуугийн гудамж, Нийслэлийн Засаг захиргааны IV байр, 10 давхарт Утас: 75757810,**
**Цахим хаяг: www.ub-procurement.mn, www.tender.gov.mn**

# ЗАВСАРЛАГА

ДУУЛГАХ СОНИН




## Түмнийг шуугиулсан барилдаан

Э.ТУУЛ

Монгол улсын арслан цолонд хүндэтгэл үзүүлэх барилдаан Монгол бөхийн өргөөнд олныг өндөлзүүлсэн барилдаанаар дүүрэн болж өндөрлөлөө. Хүндэтгэлийн барилдаанд улсын аварга Г.Эрхэмбаяр, улсын арслан Н.Батсуурь, Х.Мөнхбаатар, Р.Пүрэвдавга,улсын гарьд Ж.Бат-Эрдэнэ болон заан дөрөв, харцага найм, начин 24 зэрэг улс, аймгийн цолтой 256 бөх зодоглолоо. Арслан цолны хүндэтгэлийн барилдаан энэ жил “Алтан жолоо” группийн 25 жилийн ойн нэрэмжит болсноороо онцлог байлаа. Барилдааныг үзэхээр төрийн наадмын түрүү булаалдаж явсан үе үеийн ахмад арслангууд Ц.Бадамсэрээжид, У.Мижиддорж, Л.Сосорбарам, Ж.Хайдав, Ө.Эрдэнэ-Очир, Б.Ганбаатар нар хүрэлцэн ирж бөхөд хайртай түмэн олноо баярлууллаа. “Алтан Жолоо” групп нь 25 жилийн ойгоо тохиолдуулан бөх үзэгчдийн дунд 25 азтаныг тодруулж ,арслан цолтой бөхчүүдэд хүндэтгэл үзүүлж гарын бэлэг гардуулав. Мөн улсын арслан Н.Батсуурь, Р.Пүрэвдавга нарын хүч шавхсан барилдаан тун чиг үзүүштэй барилдаан байлаа. Аймгийн арслан О.Хангай тун онцгой байж арслан цолны хүндэтгэлийн барилдааны түрүүг авч, улсын арслан Н.Батсуурь үзүүрлэж, их шөвөгт улсын арслан Р.Пүрэвдагва, улсын начин Л.Цэрэнтогтох нар шалгарлаа. Олон сайхан ажлуудаар нийгмийн хариуцлагын хүрээнд хийж хэрэгжүүлдэг “Алтан жолоо” группийн 25 жилийн ойн барилдаан уран, тааварлашгүй барилдаанууд ихтэй, үзэгч түмнээр дүүрэн онцгой сайхан болж өндөрлөлөө.














Улаанбаатарт:

Маргааш
Өдөр 32
Шөнө 14

Нөгөөдөр
Өдөр 18
Шөнө 14

**Өдрийн зурхай**

**ХАВРЫН АДАГ ХӨХ ЛУУ САРЫН НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН ТУУЛАЙ ӨДӨР**

**Үс засуулбал:** Өлсөж ундаасна
**Наран ургах, шингэх:** 05.17-20.26



*Тухайн өдөр хонь, гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр гэмтнийг шийтгэх, угаал үйлдэх, мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Газар хагалах, ус булгийн эх малтах, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.*

**ЗАРЛАЛ**

ТЭМҮЖИН-ӨРЛӨГ ДУНД СУРГУУЛЬ НЬ 2017-2018 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТЫГ 2017ОНЫ 06-Р САРЫН 10-14 НИЙ ӨДРҮҮДЭД ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХ ИХ СУРГУУЛЬ ДЭЭР ЗОХИОН БАЙГУУЛНА

*ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ Urlug.mndu.gov.mn*

**ХОЛБОГДОХ УТАС; 458673. 99052308**

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ "ГАНЗУУ" ЭМНЭЛЭГ

Манай эмнэлэг дотор 5 цул, 6 сав эрхтэний өвчлөлийг уламжлалт анагаах ухааны таван заслын аргаар эмчилж, 80-аас дээш хувьтай үр дүн үзүүлдэг.

Бид танд:
- Ган болон мөнгөн зүү, цахилгаан зүү
-Хануур, сам соруул
-Шарлага
-Бумба төөнө засал
-Халуун чулуу, давсан халуун жин засал
-Эмчилгээний цэгэн бариа
-Архи, сүү, сүүлэн тостой бүтэн биеийн бариа зэрэг уламжлалт анагаах ухааны эмчилгээ үйлчилгээ, мэдрэл, харшил, хүүхэд, эмэгтэйчүүдийн оношлогоо эмчилгээг цогцоор нь хийж үйлчилнэ.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧАНАРТАЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ БИД ҮЗҮҮЛНЭ
Холбогдох утас: 9999-5584 9900-2332



Салбар 1 хаяг: Найрсаг Улаанбаатар их дэлгүүрийн баруун талд "Ганзүү" эмнэлэг /Өдрийн эмчилгээ/



Салбар 2 хаяг: III хороолол, 28 дугаар сургуулийн баруун талд "Ганзүү" эмнэлэг /Хэвтүүлэн эмчилнэ/